



Цагаачлалын шүүх хуралд бэлтгэх

Нэхэмжлэгчдэд зориулсан гарын авлага

Алберта муж, Калгари хот

Mongolian

Энэхүү гарын авлагын шинэчилсэн мэдээллийг дараах цахим хаягаар орж харна уу:
www.kinbrace.ca/rhp-guide/updates

ГАРЧИГ


<i>Цагаачлалын нэхэмжлэл гаргах</i>	2–15
Цагаачлал, Хамгаалалын тухай	2
Хуулийн хугацаа болон онцгой анхаарах өдрийн талаар	5
Хуулийн Зөвлөхтэй болох нь	8
Өргөдөл, (ВОС) нэхэмжлэлээ бүрдүүлэх	10
Өгрөдөл, (ВОС) нэхэмжлэлээ хүлээлгэн өгөх	13
<i>Шүүх хуралд бэлтгэх</i>	16–31
Нотлох баримт цуглуулах: Ерөнхий зүйл	16
Нотлох баримт цуглуулах: Эрхзүйн ойлголт	19
Нотлох баримт цуглуулах: Эрхзүйн ухагдахуун	22
Нотлох баримтаа хүлээлгэн өгөх	28
Шүүх хуралд бэлдэх хугацаанд эрүүл мэндээ анхаарах	30
<i>Шүүх хурлын өдөр</i>	32–37
Таны шүүх хурлын өдөр	32
Шүүх хурлын бэлтгэлийг шалгах хяналтын жагсаалт	36
<i>Шүүх хурлын дараа</i>	38–39
<i>Тодорхойлолтууд</i>	40–41
<i>Төр захиргааны байгууллагууд</i>	42–43
<i>Эх сурвалж</i>	44

Таны улс орноосоо дүрвэн гарах шалтгаан Канад улсын цагаачлалын тухай хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд танд Канадад цагаачлах эрх олгоно.

Энэхүү гарын авлага дараах зүйлийг ойлгоход танд зөвлөмж болно. Үүнд:

- Цагаачлалын нэхэмжлэлээ хэрхэн бэлтгэж эхлэх
- Цагаачлалын эрх хамгаалахтай холбоотой эрхзүйн ойлголт
- Шүүх хуралд бэлтгэл хангах хуулийн хугацаа
- Цагаачлал, Дүрвэгсдийн асуудал эрхлэх Зөвлөл(цаашид IRB)-д бүрдүүлэх нотлох баримт
- Шүүх хурлын бэлтгэлийг хэрхэн хангах
- Бэлтгэл хангахад шаардлагатай мэдээ мэдээллийн эх сурвалж
- Шүүх хурлын явц

Онцгойлон анхаарах эхний алхамууд:



Юуны түрүүнд хуулийн тусламцаа ав!

Цагаачлалын нэхэмжлэл гаргахад тань туслан зөвлөх сайн өмгөөлөгч/хуулийн төлөөлөлтэй болох арга хэмжээ ав. Өмгөөлөгч хөлслөх санхүүгийн боломжгүй бол та Алберта мужийн Хуулийн тусламжийн байгууллагад утасаар холбогдож эсвэл өөрийн биеэр хандаж хүсэлтээ гаргаж болно (9-р хуудсаас унших)!



Хугацаа алдалгүй эхэл!

Та Канадад цагаачлах зайлшгүй шаардлагатай гэдгээ батлах түүх, мөн таны түүх үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг цуглуулж эхлэх хэрэгтэй. Тэдгээрийг хугацаа алдалгүй Англи/Франц хэл дээр орчуулсан байх.

Гарын авлагад хэрэглэгдсэн товчилсон үгсийн тайлбар:

(Зарим нэр томъёог утгачилан орчуулсан болно)

BOC: Basis of Claim – Үндсэн нэхэмжлэл

CBSA: Canada Border Services Agency – Канад улсын хилийн үйлчилгээний агентлаг

CIC: Citizenship and Immigration Canada – Канадын Иргэншил болон Цагаачлалын Алба

DCO: Designated Country of Origin – Тухайлсан улс орон

DFN: Designated Foreign Nationals – Сэжиг бүхий гадаадын харьяат

IRB-RAD: Immigration and Refugee Board of Canada – Refugee Appeal Division – Канадын Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл – Цагаачлалын

талаар гарсан шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх


IRB-RPD: Immigration and Refugee Board of Canada – Refugee Protection Division – Канадын Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл-Цагаачлалын асуудал шийдвэрлэх анхан шатны шүүх

LAA: Legal Aid Alberta – Алберта мужийн Хуулийн зөвлөгөө өгөх газар

NDP: National Documentation Package – Үндэсний мэдээллийн сан

UNHCR: United Nations High Commissioner Refugees – НҮБ-ын дэргэдэх Цагаачлалын Агентлаг

Цагаачлал, Хамгаалалын тухай



Та улс орондоо аймшигт явдлыг даван туулсан, эсвэл эрхзүйн тэвчишгүй зөрчилтэй нүүр тулгарсан байж болно. Эх орондоо эргэж очиход танд туйлын аюултай, эсвэл та хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон байж болно. Тэгсэн хэдий ч эдгээр шалтгаанаар танд цагаачлах зөвшөөрөл үг дуугүй олгоно гэсэн үг биш.

Цагаачлах зөвшөөрөл авна гэдэг нь та “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенци” (цаашид “Дүрвэгсдийн Цонвенци” гэх) эсвэл “Хамгаалалд хамрагдах хуулийн этгээд” зэрэг эрх зүйн шаардлагад нийцэж байгаагаа батлах хэрэгтэй гэсэн үг. Тус гарын авлагад цаашид холбогдох эрх зүйн ойлголтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. Та зөвхөн үнэнийг хэлж байгаагаа батлах үүрэгтэй. Батлахын тулд та өөрт тохиолдсон явдалд дэлгэрэнгүй бөгөөд цэгцтэй тайлбар гаргаж үүнийгээ баримтаар нотлох ёстой.

Танд цагаачлах зөвшөөрөл олгох эсэхийг **Канадын Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл-Цагаачлалын асуудал шийдвэрлэх анхан шатны шүүх (цаашид IRB-RPD гэх)** шийднэ.

Канадад цагаачлах “хүсэлт гаргана” гэдэг нь та “цагаачлалын нэхэмжлэл боловсруулна” гэж ойлгох хэрэгтэй. Шүүхээс нэхэмжлэлд зөвшөөрсөн шийд гаргуулахын тулд та “Дүрвэгсдийн Конвенци” эсвэл “Хамгаалалд хамрагдах хуулийн этгээд” –н хууль ёсны шаардлагад бүрэн нийцэж байгаагаа батлах ёстой. Холбогдох хууль эрхзүйн нэр томъёоны тайлбарыг Канад улсын Цагаачлал, Дүрвэгсдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 96, 97 дугаар хэсгээс харах, *мөн тус гарын авлагын 20–21 дүгээр хуудсаас унших.*

Цагаачлалын нэхэмжлэлд гаргасан таны хүсэлтийг шүүх хурлаар хэлэлцэнэ. Цагаачлалын нэхэмжлэл хэлцэх шүүх хурал нь нэхэмжлэл гаргасанаас хойш 1-2 сарын хугацаанд хуралдна. Шүүх хурлын шийдвэр гаргагч нь IRB-RPD-ийн гишүүн Presiding Member байх бөгөөд таны ам мэдүүлэг, гэрчийн мэдүүлэг, ВОС/нэхэмжлэл болон холбогдох нотлох баримтыг үндэслэж танд цагаачлалын зөвшөөрөл олгох эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

★ Анхаарах зүйл: Зарим тохиолдолд, таны нэхэмжлэлийг “хурдасгасан” хэлбэрээр хэлэлцэнэ гэж IRB-аас мэдэгдэж болно. Ийнхүү мэдэгдсэн бол таны шүүх хурал ердийн журмаар явагдахгүй гэсэн үг. Хурдасгасан хурлын процессийн талаарх ойлголтыг 41 дүгээр хуудаснаас уншна уу.

Таны шүүх хуралд хянан үзэх баримт бичгүүд:

- Таны ВОС/нэхэмжлэл
- Канадын Иргэншил болон Цагаачлалын Албанд (цаашид CIC) хандсан визийн мэдүүлгийн маягтууд
- Таны бүрдүүлсэн нотлох баримтууд
- CIC болон Канадын Хилийн Үйлчилгээний Агентлагаас (цаашид CBSA)-аас ирүүлсэн баримтууд
- IRB-RPD-ийн Үндэсний Мэдээллийн Сан (цаашид NDP)-гийн мэдээлэл (*18-р хуудсаас унших*)
- Канадад ирхээс өмнө баталгаажуулсан таны гарын үсэг бүхий визийн маягт (хэрвээ визээ өөрөө мэдүүлсэн бол)
- Таны аялалын түүхийг баталгаажуулсан тамга тэмдэг бүхий таны гадаад паспорт (байгаа тохиолдолд)

Канадын цагаачлалын эрхийг хамгаалах төрийн системийн талаар мэдэх ёстой гурван чухал зүйл:

1 Канадын цагаачлал, хамгаалалын ажиллагааны систем нь түргэн шуурхай болон цаг хугацааны шахуу хуваарьтай.

Энэхүү гарын авлагаас та цагаачлалын эрхийг хамгаалалын Системтэй танилцаж хуулийн хугацааны талаар бодитой ойлголттой болно.

2 Цагаачлалын нэхэмжлэлийг шийдвэрлэх явцад гурван бие даасан төр захиргааны байгууллага оролцдог.

Таны нэхэмжлэлийг хэлэлцэх явцад эдгээр байгууллагууд тус бүр бие даасан эрх үүргийн оролцоотой бөгөөд тус бүр харилцах өөр хаягтай. Хэрвээ та оршин суугаа хаяг эсвэл холбогдох утасны дугаараа өөрчилсөн бол шинэчилсэн мэдээллийг холбогдох гурван байгууллагад тус бүрчлэн мэдэгдэх үүрэгтэй*.



IRB-RPD:

Канадын Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл-Цагаачлалын асуудал шийдвэрлэх анхан шатны шүүх



CIC:

Канадын Иргэншил болон Цагаачлалын Алба



CBSA:

Канадын Хилийн Үйлчилгээний агентлаг

3 Та Тухайлсан Улс Орны (DCO) иргэний харьяалалтай бол таны нэхэмжлэлийг бие даасан журам, түргэвчилсэн хуваарийн дагуу Хэлэлцэнэ.

Канадын засгийн газраас баталсан Тухайлсан улс орон (цаашид DCO)-ны жагсаалтанд таны иргэний харьяалал орох эсэхийг www.cic.gc.ca цахим хуудаснаас (“dco” гэж хайх) тодруулах нь чухал.

DCO-ны харьяат та мөн эсэхээ CIC болон CBSA-ийн мэргэжилтнүүдээс тодруулж болно.

DCO-ны тодорхойлолтыг 40 дүгээр хуудаснаас унших.



байгууллагын хаяг болон бусад мэдээллийг 43 дугаар хуудаснаас харна уу.

Хуулийн хугацаа болон онцгой анхаарах өдрийн талаар



Цагаачлалын нэхэмжлэлээ хаана гаргасан, та DCO –ны харьяат мөн эсэх нөхцлүүдээс танд холбогдох хуулийн хугацааны хуваарь шалтгаална.

Дараагийн хоёр хуудаснаас 2 онцгой ач холбогдолтой цаг хугацааны ойлголтыг аваарай. Таны нөхцөл байдалд зохих цаг хугацаагаа тодорхойл. Өгөгдсөн хүснэгтэнд өөрт холбогдох чухал ач холбогдолтой өдрүүдээ тэмдэглэж ав.



Би онгоцны буудлын хил нэвтрэх шалган дээр эсвэл газар бүсийн хилийн боомт, хил нэвтрэх шалган дээр нэхэмжлэлээ гаргасан.

Өдөр 0

- Хууль ёсны эрхийг тодорхойлох ярилцлагын маягт бөглөх .
- ВОС/нэхэмжлэлийн маягтыг авах.
- Шүүх хурлын товыг мэдэж авах.

Өдөр 10

Таны оршин суугаа газрын хаяг, холбогдох утасны дугаар, факсийн дугаар (байгаа бол), цахим шуудангийн (байгаа бол) хаяг зэргээ CBSA болон IRB-RPD-д мэдэгдэх эцсийн хугацаа.

Өдөр 15

Та ВОС/нэхэмжлэлээ IRB-RPD-д хүлээлгэн өгөх эцсийн хугацаа.

Миний ВОС/нэхэмжлэлийн Эцсийн хугацаа:



Шүүх хурал
болхоос 10
хоногийн
өмнө

Нотлох баримт бичгийн жагсаалтыг IRB-RPD-д хүлээлгэн өгөх эцсийн хугацаа.

Миний бичиг баримтын эцсийн хугацаа :



Өдөр 45
(ойролцоогоор)

Таны шүүх хурлын өдөр (хэрвээ та DCO-д харъяатай бол)

Миний шүүх хурлын өдөр:



ЭСВЭЛ

Өдөр 60
(ойролцоогоор)

Таны шүүх хурлын өдөр (хэрвээ та DCO-д харъяагүй бол)

Миний шүүх хурлын өдөр:



Хэрвээ та Канад улсын нутаг дэвсгэр

дотор (Хилийн боомт, хилийн шалган дээр биш)-оос саатуулагдсан бөгөөд тухайн үедээ цагаачлалын нэхэмжлэлээ гаргаж амжаагүй байсан тохиолдолд та саатуулагдсан өдөртөө, эсвэл тухайн хоногтоо багтаж нэхэмжлэлээ гаргаж шаардагдах баримтуудаа бүрдүүлж өгөх үүрэгтэй болно. Энэ нь танд нэхэмжлэл гаргахад өмгөөлөгчийн тусалцаа Авахад их төвөгтэй байдалд оруулна. CBSA-с боловсруулах баримтын маягтуудыг хүлээлгэж өгч орчуулагчийн үйлчилгээг санал болгоно.



ВОС/нэхэмжлэлийн болон шүүх хурлын хуулийн хугацааг алдаж болохгүй шүү!

Хэрвээ хуулийн хугацаанд амжаагүй бол та “онцгой хурлаар” орох үүрэгтэй бөгөөд тус хурлаар таны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох магадлалтай. Нэхэмжлэл тань хэрэгсэхгүй болсон тохиолдолд та эх орондоо буцаах шаардлага хүлээн авч ирээдүйд Канадад цагаачлах хүсэлт дахин гаргах эрхгүй болно. Заримдаа нэхэмжлэлийн эрхийг сэргээх хүсэлтийг RPD-д гаргадаг ч, энэ нь тэгэж амар бүтдэг зүйл биш. **(Анхаарах зүйл:** “онцгой хурал”-ын тов болон таны шүүх хурлын өдрийг “Шүүх хуралд оролцох мэдэгдэл” албан баримтан дээр нэг дор мэдэгднэ. Энэ хоёр өөр хурлын болон хугацааны ялгааг сайн ойлгож авараар.)



Би нэхэмжлэлээ CIC-д Канадын нутаг дэвсгэр дээрээс гаргасан/гаргана.*

CIC-д хандахаасаа өмнө:

- Шаардагдах маягтуудаа www.cic.gc.ca цахим хуудаснаас татаж вах ("make refugee claim" гэж хайх).
- Өмгөөлөгчтэй, гэр бүлийн гишүүн/гишүүд өргөдөлд Хамрагдах эсэхээс хамааран та ойролцоогоор 5-7 маягт бөглөнө. ВОС болон CIC-ийн маягтыг гэр бүлийн гишүүн тус бүрээр бөглөх ёстой.
- CIC-д өөрийн биеэр (ажлын өдрүүдэд өглөөний 10:00 цагаас өмнө) очиж бүрдүүлсэн баримтуудаа хүлээлгэж өгч, Хууль ёсны эрхтэй эсэхээ тодорхойлуулах ярилцлагын өдрийн товоо авна.

Calgary CIC Office: Harry Hays Building
Room 210, 220 – 4th Avenue SE, Calgary, AB T2G 4X3
Цагийн хуваарь: Даваа-Баасан гаргуудад 08:00 – 16:00

Цагаачлалын нэхэмжлэл хүлээн авдаг Алберта мужийн бусад CIC-ийн албан газрын хаягийг дараах цахим хаягаар орж үзнэ үү:
www.cic.gc.ca/english/information/offices/help.asp



Анхаарах:
Цагаачлалын
нэхэмжлэлээ

боловсруулж
эхлээгүй бол
Алберта мужийн
Хуулийн тусламжийн
байгууллагад хандаж
үнэ төлбөргүй
өмгөөлөгчийн
үйлчилгээг
авах эрхтэй
эсэхээ урьдчлан
торуулаарай.

Өмгөөлөгчийн
танд үзүүлж чадах
туслалцаа:

- Та хууль ёсны эрхтэй эсхийг тодорхойлох ярилцлагад бэлдхэд
- Баримт боловсруулахад
- Шүүх хуралд хуралд бэлдхэд

Өдөр 0

Шүүх хурал
болхоос 10
хоногийн
өмнө

Өдөр 30
(ойролцоогоор)

ЭСВЭЛ

Өдөр 60
(ойролцоогоор)

- Та Хууль ёсны эрхтэй эсхийг тодорхойлох ярилцлагаа өг (Ярилцлаганд орхоосоо өмнө CIC-ийн маягтууд, ВОС / нэхэмжлэхээ CIC-д хүлээлгэн өгсөн байх ёстой.)
- Таныг цагаачлалын нэхэмжлэл гаргах хууль ёсны эрхтэй гэж үзвэл танд нэхэмжлэл хэлэлцэх шүүх хурлын өдрийг тогтоож өгнө.

Нотлох баримтын жагсаалт бусад баримтаа IRB-RPD-д хүлээлгэн өгөх эцсийн хугацаа.

Миний бичиг баримтын эцсийн өдөр:



Таны шүүх хурлын өдөр (хэрвээ та DCO-н харьяатай бол)

Миний шүүх хурлын өдөр:



Таны шүүх хурлын өдөр (хэрвээ та DCO-н харьяагүй бол)

Миний шүүх хурлын өдөр:




Хэрвээ ВОС/нэхэмжлэлээ хүлээлгэн өгөх таны эцсийн хугацаа Бямба, Ням, нийтээр амрах баярын өдөр давхардсан бол түүний дараах ажлын өдрийг сонгоно. Жишээлбэл: Хэрвээ 5-р сарын 7-ны Бямба гараг нь таны шүүх хурлын өмнөх 10 хоног бол таны баримтын

эцсийн хугацаа дараагийн ажлын өдөр буюу 5-р сарын 9-ний өдрийн Даваа гарагт шилжинэ.

Таны шүүх хурлаас өмнө CBSA аюулгүйн хяналтаа гүйцэтгэж дуусаагүй тохиолдолд шүүх хурал хойшлогдоно.

Хуулийн зөвлөхтэй болох нь



Хуульч /Өмгөөлөгчтэй байх нь их ач холбогдолтой. Цагаачлалын асуудал нь хууль зүйн цогц ойлголт бөгөөд шаардлагад нийцсэн нотлох баримт бүрдүүлэх нь амар ажил биш.

Өмгөөлөгч танд “Дүрвэгсдийн Конвенци” болон “Хамгаалалд хамрагдах хуулийн этгээд” –ийн талаар хууль зүйн ойлголтыг өгч танд холбогдох эрх зүйн хамаарлыг тайлбарлаж өгнө. Танд тохиолдсон явдлаас аль хэсгийг ВОС/нэхэмжлэлдээ тусгах нь хуулийн ач холбогдолтой, шаардлагатай гэдгийг ойлгоход өмгөөлөгч танд тусална. Таны нэхэмжлэлд зайлшгүй шаардлагатай ямар нотлох баримтыг бүрдүүлэх талаар өмгөөлөгч танд зөвлөнө. Өмгөөлөгч таныг шүүх хурал дээр төлөөлөх эрхтэй.

Цагаачлалын нэхэмжлэлээ гаргахаас өмнө өмгөөлөгчтэй болох арга хэмжээ ав. Хэрвээ та нэхэмжлэлээ бие даан боловсруулсан хэдийч өмгөөлөгчгүй байсаар байгаа бол хуульч/өмгөөлөгчтэй холбогдох боломж бүрээ дайчлах хэрэгтэй. Таны өмгөөлөгч шүүх хуралд биечлэн оролцох боломжтой байх эсэхийг баталгаажуулаарай.

Алберта мужийн Хуулийн туслалцаа үзүүлэх төвд хугацаа алдалгүй хандаж үнэ төлбөргүй хуулийн туслалцаа авах хүсэлтээ гаргаарай. Хэрвээ та үнэ төлбөргүй хуулийн туслалцаа авах эрхгүй тохиолдолд танд хуулийн зөвлөгөө өгөх өөр эх сурвалжийг зааж өгнө.

Үүнээс гадна, та хувиараа өмгөөлөгч эсвэл цагаачлалын хуулийн зөвлөх хөлсөлж болно. Хэрвээ өмгөөлөгч хөлслөхөөр шийдвэл таны сонгосон өмгөөлөгч Алберта мужийн Хуулийн Нийгэмлэгийн жинхэнэ гишүүн мөн эсэхийг шалгаарай. Энэхүү мэдээллийг та Хуулийн Нийгэмлэгийн www.lawsociety.ab.ca/extra/lawyer_directory.aspx цахим хуудаснаас шалгах боломжтой бөгөөд 1-800-661-9003 тоот утсаар холбогдож лавлагаа авч болно. Хэрвээ та цагаачлалын хуулийн зөвлөх хөлсөлж байгаа бол таны зөвлөх “The Immigration Consultants of Canada Regulatory Council” буюу Канадын Зохицуулах хорооны цагаачлалын хуулийн зөвлөхийн гишүүн мөн эсэхийг шалгаарай. (www.iccrc-crcic.ca цахим хуудсаас “certified members” хайлтаар нэрийн жагсаалтыг хараарай).

Хэрвээ та зөвлөн туслах өмгөөлөгчтэй болж чадахгүй тохиолдолд ВОС/нэхэмжлэлээ өөрөө хариуцан гаргаж шүүх хуралд бие даан оролцох үүрэгтэй. Үүнээс гадна, таны итгэл хүлээлгэсэн хэн нэгний сайн дурын/үнэ төлбөргүй туслалцааг авч болно. Олон нийтийн агентлагаас (44 дүгээр хуудас) таны оршин суугаа газарт нутагт үйл ажиллагаа явуулдаг хуулийн зөвлөгөө үзүүлэх эх сурвалжийг зааж өгнө.

Алберта мужийн хуулийн туслалцаа үзүүлэх төв Legal Aid Alberta

Standard Life Tower
1800, 639 5 Avenue
Calgary, AB T2P 0M9

1-866-845-3425

www.legalaid.ab.ca

Цагаачлалын хууль ёсны нэхэмжлэгчдийг эрх зүйн мэдээллээр хангаж хуулийн зөвлөгөө өгч тэдгээрийг шүүх хуралд итгэмжлэн төлөөлнө.

Калгари хотын хуулийн хөтөч Calgary Legal Guidance

100, 840 – 7th Avenue SW

403-234-9266

www.clg.ab.ca

Цагаачлалын нэхэмжлэгчийн горилогч хуулийн этгээдэд эрхзүйн үнэ төлбөргүй мэдээлэл болон хуулийн зөвлөгөө өгнө.




Надад одоогоор өмгөөлөгч байхгүй, шүүх хуралдаа бэлтгэл хангаагүй. Би шүүх хурлаа хойшлуулж болох уу?

IRB-RPD таныг шүүх хуралдаа хуулийн заасан хугацаанд бэлтгэгдсэн байхыг шаардна. Хэрвээ шүүх хурлыг зайлшгүй хойшлуулах хүндэтгэх шалгаан танд байгаа бол та шалтгаанаа тайлбарласан хурлыг хойшлуулах хүсэлтээ IRB-RPD-д бичгээр гаргана. Шүүх хурлын өдрөөс өмнө таны хүсэлтэнд хариу ирүүлээгүй бол та товлогдсон хуралдаа оролцох ёстой, үгүй бол таны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно (40 дүгээр хуудсыг унш). Шүүх хурал товлогдсоноос хойш та өмгөөлөгчтэй болсон бол таны өмгөөлөгч шүүх хуралд биечлэн оролцох боломжтой эсэхийг баталгаажуулаарай.



Энэ бол таны цагаачлалын эрх хүсэмжилсэн нэхэмжлэл. Та хуулийн заасан хугацааг алдвал таны нэхэмжлэлийг хэрэгсэхгүйд тооцно. Та хэдийгээр өмгөөлөгчтэй байлаа ч бичиг баримт бүрдүүлэх, нотлох баримт болон гэрчийн мэдүүлэг цуглуулах, батламж бэлдэх зэрэгт та хувийн зүгээс идэвхи санаачлагатай оролцох ёстойг ойлгоорой.

Өргөдөл, (ВОС) нэхэмжлэлээ бүрдүүлэх



Таны нэхэмжлэлийн бүрдүүлэлтийн хамгийн чухал баримт бичиг бол таны ВОС дэлгэрэнгүй түүх. Энэхүү баримт бичигт та хэн болох, яагаад Канадад орогнол хүсэх болсон талаар дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгнө. Канадын Цагаачлал, Дүрвэгсдийн асуудал эрхлэх Зөвлөлийн - Цагаачлал, Хамгаалалын Хорооны (IRB-RPD) гишүүн таны нэхэмжлэл, мэдүүлэг болон бусад холбогдох баримтуудыг хянан үзэж таныг “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенци” (Дүрвэгсдийн Конвенци), “Хамгаалалд орох эрх бүхий этгээд” мөн эсэхийг шийднэ. Цагаачлалын зөвшөөрөл хэлэлцэх шүүх хуралд таны нэхэмжлэлд үндэслэж асуулт тавьж тодруулга хийнэ.


ВОС/нэхэмжлэл болон бусад баримтаа бүрдүүлэхдээ өмгөөлөгчийн туслалцаа авахыг бодоорой. Боломжгүй тохиолдолд бичиг цаасны ажлаа эхлэхээс өмнө хуульчид хандаж шаардлагатай мэдээллин талаар зөвлөгөө аваарай (9 дүгээр хуудсаас унш). Та ВОС-ийн маягт, бусад бичиг баримтаа боловсруулж эхлэхээсээ өмнө IRB-RPD-с тавигдах эрх зүйн шаардлагыг ойлгосон байх нь чухал.

ВОС маягтанд орох таны мэдээлэл **аль болох цэгцтэй , мэдээлэл орхигдуулаагүй** байх ёстой. Хэрвээ тантай холбогдох бусад баримт бичигт

– жишээлбэл таны визийн мэдүүлэг т – буруу ташаа мэдээлэл байгаа тохиолдолд өмгөөлөгчдөө мэдэгдэж үнэн зөв мэдээллийг ВОС-ийн маягтанд оруулах үүрэгтэй. Асуултанд таамгаар хандаж болохгүй. Хэрвээ та хариулж мэдэхгүй асуулт гарвал мэдэхгүй байна гэдгээ бич . Шударга үнэнч бай. Хэрвээ та асуултыг ойлгохгүй байгаа бол өмгөөлөгчөөр эсвэл нийгмийн ажилтнаар тодруулан тайлбарлуул. Та худал мэдүүлэг, төөрөлдүүлэх мэдээлэл өгч, чухал баримтыг нуун дарагдуулвал таны цагаачлалын нэхэмжлэлийг хүчингүйд тооцно.

ВОС/нэхэмжлэлээ бүрдүүлэхэд анхаарах зүйлс:

- Тус гарын авлагын “Эрх зүйн ойлголт ” мөн “Эрх зүйн асуудлууд” хэсгүүдийг анхааралтай уншаарай. Танд ВОС/нэхэмжлэлээ боловсруулах нэмэртэй (19–27 дугаар хуудас).
- Нэхэмжлэлээ Англи/Франци хэл дээр боловсруулна. Хэлний бэрхшээлтэй тулгарч байгаа бол цагаачлалын нэхэмжлэгчдэд туслалцаа үзүүлдэг мэргэжлийн байгууллагад ханд (44 дүгээр хуудас). ВОС/нэхэмжлэлийн албан маягтыг www.irb-cisr.gc.ca цахим хуудсаас татаж авах.
- Асуулт бүрт хариулах ёстой. Дутуу, хоосон асуулт үлдээж болохгүй. Хариулж мэдэхгүй асуулт гарвал “ХАРИУЛЖ МЭДЭХГҮЙ БАЙНА” гэдгээ бич.
- Асуулт танд огт хамааралгүй тохиолдолд “n/a” (“not applicable” - хариулах боломжгүй) гэж бич.
- Асуулт бүрийг хариулахаасаа өмнө анхааралтай уншиж ойлгож ав.
- Гаргацтай, нямбай бичиж эсвэл компьютероор шивэх.
- Асуултанд бүрэн, дэлгэрэнгүй хариулт өгөхөд маягтын зай хангалтгүй бол нэмэлт хуудас ашигла.
- **Хэрвээ та саатуулагдсан бол саатуулагдсан байгаагаа мэдэгдэж** мөн шалтгаанаар нэхэмжлэлд шаардагдах баримтыг бүрэн боловруулах боломж хязгаарлагдмал байгаа тул хариулт дутмаг, цэгцгүй байх магадлалтай гэдгээ бичиж өгнө. Үүнийг ВОС-ийн арын хуудсанд гарын үсгийнхээ зэрэгцээ бичнэ.
- Тодорхой өдөр, хоног, бусад мэдээллийг баттай хэлж мэдэхгүй байгаа бол та үүнийгээ ВОС/ нэхэмжлэлдээ тусган бичнэ. Нэхэмжлэлд зөвхөн хөдөлшгүй баримт, мэдээллийг тусгана.
- Боловсруулсан таны ВОС/нэхэмжлэл, СIС-д бүрдүүлсэн баримтууд хоорондоо мэдээллийн зөрөөгүй, хоорондын уялдаа холбоотой эсэхийг нягтлан шалга.
- ВОС/Нэхэмжлэл боловсруулахдаа орчуулагчийн туслалцаа авсан бол нэхэмжлэлийг танд эх хэлээр хөрвүүлэн уншиж өгөхийг орчуулагчаасаа хүсэмжлээрэй.
- ВОС/нэхэмжлэлийн маягтын 10 дугаар хуудсан дээр орчуулагчаар гарын үсэг зуруулаарай.



- Нэхэмжлэлийн мэдээ мэдээлэл алдаа дутагдалгүй болсон цагт ВОС/нэхэмжлэлийн 10 дугаар хуудсанд та гарын үсгээ зурах ёстой. Нэхэмжлэлийг гарын үсгээр баталгаажуулахаасаа өмнө та нягталж амжаагүй, зарим мэдээллийг цаг хугацааны улмаас орхигдуулсан бол үүнийгээ ВОС/нэхэмжлэлдээ заавал тусгаарай.
- Канадад цагаачлах, орогнол, хамгааллыг хүссэн гэр бүлийн гишүүн тус бүрээр ВОС/нэхэмжлэл бүрдүүлнэ.

Та хуулийн зөвлөх/өмгөөлөгчгүй бол:

- Боломжтой бол цагаачлалын хуулиар туршлагажсан мэргэжилтнээр нэхэмжлэл, маягтаа хянуулаарай.
- IRB-ийн цахим хуудсаас Нэхэмжлэгчийн Хөтөчөөс нарийвчилсан зааварчилгааг аваарай. (www.irb-cisr.gc.ca руу орж “claimants guide” гэж хайх).

Бусад албан маягтууд:

ВОС/нэхэмжлэлээс гадна та СІС дараах маягтыг боловсруулж өгөх шаардлагатай.

- Баримтын жагсаалт
- Канад зорчих өргөдлийн мэдүүлгийн ерөнхий маягт
- Таны хараат хүмүүсийн талаарх мэдээ/мэдүүлэг
- Хавсралт А – Анкет/мэдүүлэг
- Хавсралт 12 –Нэмэлт мэдээлэл- Цагаачлалын нэхэмжлэлийн мэдүүлэг (Канад улс дотроос өргөдөл гаргах маягт)
- Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт (Өмгөөлөгч /цагаачлалын хуулийн зөвлөхтэй тохиолдолд)

Та цагаачлалын нэхэмжлэлээ Канад улсын Олон улсын онгоцны буудлын эсвэл газраар хил нэвтрэх бүс дээрээс гаргаж эхэлсэн бол дээрх маягтуудыг Канадын Хилийн Үйлчилгээний Агентлаг (цаашид CBSA-т бүртгүүлэхдээ бөгөлсөн байгаа.

Та цагаачлалын нэхэмжлэлээ СІС-д Канад улсад орж ирснээсээ хойш гаргаж байгаа бол та тус албанд өөрийн ВОС/нэхэмжлэл, СІС –ийн баримтуудаа зэрэг хүлээлгэж өгөх ёстой. Шаардлагатай баримтуудыг тоо ёсоор хүлээлгэж өгөөгүй тохиолдолд хууль ёсны нэхэмжлэгчийн эрхийг тодорхойлох ярилцлаганд орох зөвшөөрөл танд олгохгүй . Баримт боловсруулах заавачилагааг www.cic.gc.ca (“refugee application package” гэж хайх) цахим хуудаснаас харж уншаарай.




Би өөрийн хараат хүүхдүүддээ тус бүрээр нь ВОС/нэхэмжлэл гаргах ёстой юу?

6 болон түүнээс доош насны хүүхэд эцэг/эхийн хамт цагаачлах хүсэлт гаргаж байгаа бол ВОС маягтын 2 дугаар хуудсын зөвхөн 1a-1g хэсгийг бөглөх шаардлагатай. Маягт хүүхдийн эцэг/эх, Тухайлсан

хариуцагч (40 дүүгээр хуудас)-ийн гарын үсгээр баталгаажсан байх ёстой. Эцэг/эхийн хамт цагаачлалын хүсэлт гаргаж байгаа 7 буюу түүнээс дээш насны хүүхэд ВОС/нэхэмжлэлийг тус бүр бүрдүүлэх үүрэгтэй. Хүүхдийн холбогдох баримт түүний эцэг/эх, Тухайлсан хариуцагчийн гарын үсгээр баталгаажсан байх ёстой.

Өргөдөл (ВОС) нэхэмжлэлээ хүлээлгэн өгөх



Та холбогдох албанд ВОС/нэхэмжлэлээ хүлээлгэн өгөхөөсөө өмнө өмгөөлөгчийнхээ хамт хянаарай. Нэхэмжлэл бүрэн гүйцэд, эмх цэгцтэй, агуулга ойлгомжтой эсэхээ нягтлан шалгаарай. Та нэхэмжлэлээ бие даан боловсруулж байгаа тохиолдолд өмгөөлөгчөөр эсвэл хуулийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх газрын мэргэжилтнээр, тэдгээр нь боломжгүй бол таны итгэл хүлээсэн хувь хүнээр уншуулж хянуулаад таны нэхэмжлэлийн агуулга маш тодорхой, шаардагдах чухал баримт бүгд бүрдсэн эсэхийг нягтлан шалгаарай.





Хүлээлгэж өгөх ВОС/нэхэмжлэл түүнтэй холбогдох аливаа баримт, маягт зэргийн хуулбар хувийг өөртөө заавал авч үлдээрэй.

Та цагаачлалын нэхэмжлэлээ гаргах газраас шалтгаалж ВОС/нэхэмжлэлийн баримтаа хаана, хэзээ болон хэрхэн хүлээлгэж өгөх ёстой нь шийдэгднэ.


А. Та нэхэмжлэлээ Канад улсын Олон улсын онгоцны буудлын эсвэл газрын хил нэвтрэн өнгөрүүлэх газар гаргасан тохиолдолд:

Та боловсруулж бэлэн болгосон ВОС/нэхэмжлэлээ маягт хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор IRB-RPD-д хүлээлгэж өгөх үүрэгтэй. Хэрвээ таны баримт хүлээлгэж өгөх хугацаа Бямба, Ням эсвэл нийтээр амрах баярын өдөр таарсан бол дараах ажлын өдрийг эцсийн хугацаа гэж үзнэ.



IRB-RPD

300 West Georgia Street, Suite 1600
Vancouver, BC V6B 6C9




? Би ВОС/нэхэмжлэлээ хугацаандаа бүрдүүлж амжихгүй бол яах вэ?

Та гэнэтийн нөхцөл байдлаас болж ВОС/нэхэмжлэлээ хуулийн заасан хугацаанд бүрдүүлж амжихгүй бол эцсийн хугацаа болхоос 3 хоногийн өмнө IRB-RPD-д хугацаа сунгах хүсэлтээ бичгээр гаргах


ёстой. Тус албанаас танд хариу ирүүлээгүй тохиолдолд хуулиар заасан эцсийн хугацаандаа багтаж ВОС/нэхэмжлэлээ бүрдэлт дутуу байсан ч гэсэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. ВОС/нэхэмжлэлийг заасан хугацаанд бүрэн бүрдүүлж амжаагүй шалтгаанаа тайлбарласан захидлыг та нэхэмжлэлдээ хавсаргаж өгөөрэй.

В. Та CIC-д цагаачлалын нэхэмжлэлээ Канад улс дотроос гаргаж байгаа тохиолдолд:

Та ВОС/нэхэмжлэл болон бусад маягтуудаа өмгөөлөгчтэйгээ хамт боловсруулаарай (өмгөөлөгчтэй бол).



Та бүрэн гүйцэт боловсруулсан ВОС/нэхэмжлэлийн 2 хувь, CIC-ны маягтуудын 1хувь хуулбарыг хийж аваарай.



ВОС/нэхэмжлэлийн эх болон 1 хуулбар хувь, CIC-ны маягтуудын эх хувь, өөрийн болон нэхэмжлэлд хавсаргасан гэр бүлийн гишүүн тус бүрийн 4 хувь цээж зургийг CIC-нд хүлээлгэж өгнө. (Хаягийг 7 дугаар хуудсаас харах). Цээж зурагт тавигдах шаардлагыг www.cic.gc.ca цахим хуудасны

“Appendix A: Photo Specifications” хавсралтаас уншаарай. Аливаа баримтынхаа хуулбар хувийг авч үлдэж байгаа анхаараарай.

(Та холбогдох байгууллагад баримтаа хүлээлгэж өгөхөд CIC-ны мэргэжилтэн таныг Канад улсад цагаачлах нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг тодорхойлох ярилцлаганд орох өдрийг хэлж өгнө. Ярилцлагын өдөр CIC-ны мэргэжилтэн таныг нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзвэл таны ВОС/нэхэмжлэлийг IRB-RPD руу шилжүүлж таны нэхэмжлэлийг хэлэлцэх шүүх хурлын өдрийг товлож өгнө).



Бүрдүүлсэн баримт бичгээ CIC-нд хүлээлгэн өгөхдөө та паспорт эсвэл өөр биеийн байцаалтаа биедээ авч очоорой. CIC таны биеийн байцаалтын эх хувийг бүртгэлдээ авч танд хуулбарыг өгнө.

Тухайн үед таны зүгээс бэлэн болгосон нэмэлт баримт, Тухайн үед таны зүгээс бэлэн болгосон нэмэлт баримт, материал байгаа бол тэдгээрийг шүүх хурал явагдах хэл (Англи/Франц)- эр орчуулсан байх үүрэгтэй. Баримт бүрийг 3 хувь үйлдэж 2 хувийг ВОС/нэхэмжлэлийн хамт CIC-нд хүлээлгэн өгч, үлдсэн 1 хувийг өөрт хадгална. Таны өмгөөлөгч баримтуудыг CIC-д хүлээлгэн өгөхөөс өмнө урьдчилан танилцсан байх ёстойг анхаарна уу.



Би ВОС/нэхэмжлэлдээ зайлшгүй тусгах ямар нэг зүйл орхигдуулсан эсвэл алдаа гаргасан бол яах вэ?

Та эсвэл таны өмгөөлөгч IRB-RPD-нд нэн даруй холбогдож дараах арга хэмжээг авна:

- Өөрт байгаа ВОС/нэхэмжлэлийн хуулбар хувь дээр оруулсан өөрчлөлт/засвартай хэсгийн доогуур зур. Өөрчлөлт/засвар бүрийн зэргэлдээ гарын үсгээ зурж огноог тэмдэглэнэ.
- Яагаад өөрчлөлт/засвар оруулах болсон тайлбарыг бичгээр гаргахдаа төгсгөлд нь “Миний оруулсан

(эдгээр) өөрчлөлт/засвар (бүр) нь бүрэн гүйцэд, үнэн зөв, алдаа зөрчилгүй болохыг батлан тангараглаж байна” гэж бичээд гарын үсгээр баталгаажуулж он сараа бичнэ.

- Та ВОС/нэхэмжлэлийн эх баримтын 1 хувь хуулбар, өөрчлөлт/засвар орсон хуудас зэргийг тайлбар захидлын хамт шүүх хурал болохоос (хамгийн багаар) 10 хоногийн өмнө IRB-RPD-д хүргүүлэх үүрэгтэй.
- Аливаа баримтын хуулбарыг өөртөө авч үлдэж байгаарай.

Нотлох баримт цуглуулах: Ерөнхий зүйл



Таны нэхэмжлэлийг нотлох баримт бүрдүүлэх нь маш ач холбогдолтой. Танд өөрийн улс оронд тохиолдсон явдал нь үнэн түүх болохыг нотлох хангалттай баримт цуглуулах хэрэгтэй гэсэн үг. Шүүх хурлын шийдвэр гаргагч IRB-RPD-ны Presiding Member эдгээр баримтуудад тулгуурлан танай улс орон дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар бодитой ойлголт авхад их тустай. **Таны баримт бичгүүд IRB-RPD-нд хүлээлгэж өгөхөөс өмнө Англи/Франц хэл дээр орчуулагдсан байх ёстойг анхаарна уу.**

Одооноос нотлох баримтаа цуглуулж эхлээрэй! Та өмгөөлөгчтэй бол нэхэмжлэлд онц шаардлагатай ямар онцлох нотлох баримт байх ёстойг асууж цуглуулж бүрдүүлсэн нотлох баримтаа өмгөөлөгчдөө цаг тухайд нь танилцуулж байх нь чухал. Нотлох баримтаа орчуулж өмгөөлөгчөөрөө хянан уншуулах хангалттай хугацаа гаргаарай.

Еөрөнхийдөө, та хоёр төрлийн нотлох баримт бүрдүүлэх үүрэгтэй.

1 Таны нэхмжлэлд онцлох нотлох баримт.

а Танд бодитой аюул тулгарч байгааг нотлох баримтын төрөл:

- Танд тохиолдсон явдлыг харуулах гэрэл зураг, захидал, дүрст бичлэг, имэйл, эсвэл өөр яамар нэгэн баримт байгаа юу? Яаралтай олж ав.
- Тусламж ирж цагдаа, эсвэл өөр төрийн үйлчилгээний байгууллагад хандаж байсан үү? Та тэдгээр байгууллагад хандсан, очсоныг нотлох цагдаагийн бүртгэл, тэмдэглэл, бусад баримтын хуулбар хувийг олж ав.
- Эмнэлэгийн туслалцаа авч байсан үү? Эмчийн тодорхойлолт, эсвэл өвчтний түүхийн тэмдэглэлийн хуулбар хувийг олж ав.
- Таны хэрэгт холбогох этгээдийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтлэгдэж байсан үү? Мэдээллийг олж ав.
- Танд тохиолдсон явдлыг гэрчлэх хүн байгаа юу? Болсон явдлыг бичээд танд явуулахыг хүсэмжил. Боломжтой бол гэрчийн мэдүүлгийн батламжийг хуульчаар эсвэл нотариатаар баталгаажуул.
- Тантай ижил төстэй нөхцөл байдалд орж байсан таны танил хүн байгаа юу? Тохиолдсон явдлаа танд бичиж явуулахыг хүсэмжил. Боломжтой бол гэрчийн мэдүүлгийн батламжийг хуульчаар эсвэл нотариатаар баталгаажуул.
- Нэхэмжлэл гаргах болсон таны шалтгаан таны шашин шүтлэг, улс төрийн намын эсвэл нийгмийн бүлэг бүрэлдэхүүн, байгууллагын гишүүнчлэлд тулгуурлаж байгаа юу? Таны гишүүнчлэлийг нотлох баримтыг бүрдүүл.
- Танд тохиолдсон үйл явдлаас танд сэтгэл санааны хохирол учирсан үү? Таны эрүүл мэнд, түүнтэй холбогдох эмгэг, нөхцөл байдлын талаар гаргасан Канадын эмч, сэтгэл судлаачийн дүгнэлтийг гаргуулж ав. Мэргэжлийн дүгнэлт гаргуулахад хугацаа их шаардагдах тул цаг алдалгүй хөөцөлдөж уулзалтаа товлоорой. Шүүх хуралаас өмнө мэргэжилтний дүгнэлтийг гаргуулж авч амжихгүй тохиолдолд IRB-RPD-нд хандсан тайлбар захидал бичиж түүндээ та мэргэжилтний дүгнэлт гаргуулахын тул яамар арга хэмжээ авсан, дүгнэлт хэдийгээр гарах төлөвтэй байгааг заавал тусгаарай. Мөн захианд IRB-RPD-ноос мэргэжлийн дүгнэлт гарах хүртэл хугацаанд шүүх хурлыг хойшлуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлээрэй. *IRB-RPD-ноос таны шүүх хурлын товыг өөрчлөхгүй байж болох.* Тийм тохиолдолд шүүх хуралдаа товолсон өдрөө оролцож танд тохиолдсон үйл явдлаас танд сэтгэл санааны ямар хохирол учирсан, бие эрүүл мэндийн ямар шалтгаанаас танд ой санамжийн асуудал гарсан, яагаад мэдээлэл бүрэн өгөх чавдаргүй байгаагаа дэлгэрэнгүй тайлбарлаарай.



? Дүрст бичлэг, вэб хуудас болон бусад цахим/электрон нотлох баримт заавал орчуулагдсан байх ёстой юу?

Тийм! Таны хэрэгт холбогдох аливаа баримт заавал Англи/Ф ранци хэл дээр орчуулагдсан байх ёстой. Дүрст бичлэгийн яриаг орчуулгын хамт сийрүүлэн бичсэн байх ёстой. Орчуулганд их зардал шаардагдах магадлалтай. Та бүх баримтаа орчуулуухад санхүүгийн

бэрхшээлтэй байгаа бол нэн чухал баримтаа сонгоод орчуулуулаарай. Санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан өөрт байгаа баримтуудаас зөвхөн нэн чухал баримтыг орчуулуулсан болно гэдгээ IRB-RPD-нд мэдэгдээрэй. Орчуулж чадаагүй нотлох баримтуудаа та шүүх хуралдаа авч очоод шүүх хурлын шийдвэр Гаргагч Presiding Member –т баримтын агуулгыг танилцуулан үзүүлээрэй.

b Та яагаад эх орондоо аюулгүй амьдрах нөхцөл боломжгүй болсоноо нотлоход эхлээд таны иргэншил, улс орны харьяалалыг батлах таны биеийн байцаалт хэрэгтэй болно (*23 дугаар хуудсаас жишээг харгах*). Та биеийн байцаалтаа цагаачлалын нэхэмжлэл гаргах эрхийг тодорхойлох ярилцлагаас хойш гар дээрээ авсан бол биеийн байцаалтынхаа хуулбар хувийг IRB-RPD-нд цаг алдалгүй хүргүүлэх хэрэгтэй.

2 Танай улс орон дахь хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлох нотлох баримт:

Хүний эрхийн зөрчил, улс төрийн үйл явдал, болон таны түүхэнд холбогдох мэдээ мэдээллийн талаар хариуцлага бүхий байгууллагын гаргасан тайлан мэдээ зэрэг нь нотлох баримтын энэ төрөлд багтна.

Жишээлбэл:

- IRB-RPD-ны Үндэсний Мэдээллийн Санг (цаашид NDP)-ийн танай улс орны талаарх мэдээллийг www.irb-cisr.gc.ca цахим хаягаас (*NDP хайлтаар өөрийн улс орны нэрийг оруулах*) уншиж болно.

Тус санд орсон мэдээллийг IRB-RPD-ны судалгааны алба боловсруулсан болно. Сангийн мэдээлэлд танай улс орны орчин цагийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг ангилан оруулсан байгаа. Танд хамаарах ангилалын мэдээллийг уншиж танилцаарай. Шүүх хурлын шийдвэр гаргагч Presiding Member таны цагаачлалын нэхэмжлэлийг хянан шалгахдаа тус сангийн мэдээ мэдээллийг ашиглана. Тус сангийн багцад байгаа тайлан, мэдээ мэдээллүүд он цагийн хоцрогдолтой байхыг үгүйсгэхгүй. *Тиймээс та өөрийн боломжоор хамгийн сүүлийн үеийн мэдээ тайланг олж өгөх хэрэгтэй.*



- Хүний эрхийг хамгаалах байгууллагуудын сүүлийн үеийн тайлан (Amnesty International, Human Rights Watch г.м) НҮБ-ын тайлан, танай улс оронд хүний эрх хөндөгдсөн сүүлийн үеийн сонин хэвлэл мэдээллийн нийтлэл, болон дүрст бичлэг зэрэг баримтууд болно. Зарим мэдээ болон баримтууд дээр дурьдсан мэдээллийн санд орсон байгаа ч таны мэдэх сүүлийн үеийн баримт мэдээ орсон байгаа эсэхийг та шалгаарай. Үүнээс гадна, танай улс орон дахь нөхцөл байдлын талаарх мэдээллийг www.kinbrace.ca/rhp-guide/country-conditions цахим хуудаснаас харж болно.
- Танай улс орны хүний эрхийн байгууллагын тайлан мэдээ болон сонин, хэвлэл мэдээллийн нийтлэл зэрэг нь нотлох баримтын энэ төрөлд орно.



Би шүүх хурлаасаа өмнө зарим нэг нотлох баримтыг олж авч амжаагүй бол яах вэ?

Та нотлох баримтаа бүрдүүлж чадаагүй шалтгаанаа шүүх хурал дээр тайлбарлах үүрэгтэй. Нотлох баримт бүрдүүлэхийн тул та өөрийн зүгээс авсан арга хэмжээ (цахим шуудан ашигласан, захидал

явуулсан, холбоо харилцаа, тогтоосон)- ний талаар тайлбарлаж хийсэн оролдлогын огноо, цаг хугацааг шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Өгсөн мэдээллийг нотолж холбогдох бичиг баримт, хуулбар, үйлчилгээний тасалбар зэргийг та шүүх хуралдаа авчирарай.

Нотлох баримт цуглуулах: Эрх зүйн ойлголт



Шүүх хуралд ялахын тулд та Цагаачлал болон Дүрвэгсдийн эрхийг хамгаалах тухай хуулиар баталгаажсан “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенци” эсвэл “Хамгаалалд хамрагдах хуулийн этгээд” зэрэг эрхзүйн ойлголтод бүрэн нийцэхээ хөдлөшгүй нотлох баримтаар батлах хэрэгтэй. IRB-RPD таны нэхэмжлэлийг дүгнэхдээ дээр дурьдсан эрх зүйн тодорхойлолтын аль нь танд хамаарахыг шинжлэн үзнэ. Хэрвээ та нэгээс дээш улс орны иргэн харьяалалтай эсвэл байнгын оршин суух эрхтэй тохиолдолд тэдгээр улс орны аль алинд нь танд амьдрах, оршин суухад аюултай байгаагаа нотлох үүрэгтэй. Шүүх хурлын явцад IRB-RPD-ны Presiding Member ямар нөлөө бүхий хүчин зүйлийг онцлон харгалзах болон та эрх зүйн ойлголтод нийцүүлж ямар төрлийн нотлох баримт цуглуулах талаар дараа хуудсанд ойлголт өгнө.

Зарим нотлох баримтын жишээг энэхүү гарын авлагын 17, 18 болон 23–27 дугаар хуудсаас олж уншаарай.

“Convention Refugee” буюу “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенци” (“Дүрвэгсдийн конвенци”)-ийн талаарх хууль эрхзүйн ойлголт

(Цагаачлал болон дүрвэгсдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 96 дугаар зүйл)

Та “Дүрвэгсдийн Конвенци”-шаардлагад нийцэхийн тул доорх 6 шалгуур үзүүлэлтийг биелүүлнэ:

Энэ нь танд хамааралтай юу?

Үүнийгээ та яамар баримтаар нотлох вэ?

1 Хэрвээ би эх орондоо буцвал надад дарамт учрах бодитой нөхцөл байгаа

(эрх зүйн шалтгаан: Дарамт, шахалт)

Мөн

41 дүгээр хуудсаас унш

2 Энэ дарамт нь миний арьс өнгө/ шашин шүтлэг/ яс үндэс/ улс төрийн үзэл баримтлал/ болон нийгмийн тодорхой бүлэг* -ийн гишүүнчлэлтэй холбоотой.

(Анхаарах: “нийгмийн бүлэг”-д бэлгийн хандлага, эрүүл мэнд, гэр бүл, үйлдвэрчний г.м нэгдсэн ашиг сонирхолын нэгдэл, бүлэг, байгууллагыг хэлнэ)

Мөн



3 Би эх орондоо буцаж очихоос үнэхээр их айж байна.

(Эрх зүйн шалтгаан: Субъектив айдас)

Мөн

24 дүгээр хуудсаас унш

4 Манай улс оронд үүсээд байгаа нөхцөл байдлаас болж надад аюул тулгараад байгаа.

Мөн



5 Манай улсын төр засгаас намайг хамгаалж чадахгүй.

(Эрх зүйн шалтгаан: Төрийн хамгаалал)

Мөн

26 дүгээр хуудсаас унш

6 Надад улс орныхоо хаана ч аюулгүй амьдрах нөхцөл боломж байхгүй эсвэл надад – миний байгаа нөхцөлд - улс орныхоо хаашаа ч очих боломж байхгүй.

(эрх зүйн шалтгаан: Шилжилт хөдөлгөөний)

26 дүгээр хуудсаас унш

***** Хэрвээ та эмэгтэй бол эмэгтэйчүүдэд тулгардаг дарамтын онцгой төрлүүд болон тэдгээрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх цахим хуудаснаас уншаараай.

UNHCR гарын авлага:
www.refworld.org/pdfid/3d36f1c64.pdf

IRB –ийн гарын авлага
www.irb-cisr.gc.ca/Eng/BoaCom/references/pol/GuiDir/Pages/GuideDir04.aspx

Хэрвээ та бэлгийн цөөнхийн төлөөлөл бол та UNHCR-с эрхлэн гаргасан бэлгийн хандлага, түүнд суурилсан дарамтын талаар гарын авлагыг унших сонирхож магад. Гарын авлагыг цахим хаягаар орж үзээрэй.

www.unhcr.org/509136ca9.pdf

“Person in Need of Protection” буюу “Хамгаалалд хамрагдах этгээд”- ийн талаарх хууль эрх зүйн ойлголт

(Цагаачлал болон Дүрвэгсдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 97 дугаар зүйл)

Та “Хамгаалалд хамрагдах этгээд”-ийн шаардлагад нийцэхийн тулд доорх 2 шалгуур үзүүлэлтийн нэгийг нь хангасан байх ёстой:

Энэ нь танд хамааралтай юу?

Үүнийгээ та яамар баримтаар нотлох вэ?

1 Хэрвээ би улс орондоо буцаж очвол надад эрх баригчдын зүгээс ял шийтгэл тулгана.




ЭСВЭЛ

2 Хэрвээ би улс орондоо буцаж очвол миний амь насанд заналхийлнэ, эсвэл санаанд багтамгүй онц хэрцгий явдал надад тохиолдно.




Мөн

a Төр засаг намайг хамгаалж чадахгүй (Эрх зүйн шалтгаан: Төрийн хамгаалал)



Мөн


b Надад улс орныхоо хаана ч аюулгүй амьдрах нөхцөл боломж байхгүй эсвэл надад – миний байгаа нөхцөлд - улс орныхоо хаашаа ч очих боломж байхгүй.



(эрх зүйн шалтгаан: Internal Flight Alternative)

Мөн


c Аюул зөвхөн миний хувь хүний биед/ганцхан надад тулгарч байгаа бөгөөд энэ нь улс орны нийт хүн амд огт хамаагүй.



(эрх зүйн шалтгаан: Тодорхой аюул)

Мөн

d Манай улс орон намайг Канадад гэмт хэрэгт тооцогдох үйлдэл хийсний минь төлөө яллах эрсдэлтэй учраас биш.



(эрх зүйн шалтгаан: Дарамт шахалын бус яллуулах айдас)


Мөн

e Манай улс оронд тахир дутуу хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээний ээлтэй орчин дутмаг учраас биш.



(Та ялгаварлан гадуурхагдсан учраас эмнэлэгийн үйлчилгээ авч чадаагүй бол үүнийг эрх зөрчигдсөн гэж үзэх тул таныг хамгаалалтанд хамруулах үндэслэлтэй)

Нотлох баримт бүрдүүлэх: Эрхзүйн ухагдахуун



Шүүх хуралд танд хамруулах зарим нэг эрх зүйн асуудлууд :

- Биеийн байцаалт
- Итгэл Үнэмшил
- Субъектив айдас
- Тодорхой аюул
- Төрийн хамгаалал
- Дотоодод орогнох хувилбар/сонголт
- Бусад улс оронд оршин суух хууль ёсны эрх

Эдгээр ухагдахууны “Дүрвэгсдийн Конвенци” эсвэл “Хамгаалалд хамрагдах хуулийн этгээд” гэх эрхзүйн ойлголтонд дараах ойлголтын холбоос тус бүр ялгаатай.

Дараагийн хуудсанд өгөх эрхзүйн ухагдахуунуудын тайлбарыг анхааралтай уншаарай. Ухагдахуун тус бүрд тохируулан бүрдүүлэх нотлох баримтын жагсаалтаа тэмдэглэж аваарай.

Таны нэхэмжлэлд зайлшгүй чухал нэмэртэй ямар нотлох баримт байх ёстой талаар өмгөөлөгчийнхөө зөвлөгөөг аваарай.

Биеийн байцаалт

Та хэн болхоо IRB-RPD-нд нотлох хэрэгтэй. Үүнд таны үндсэн харьяаллыг батламжлах паспорт, хэрвээ танд байгаа тохиолдолд өөр улс оронд урт хугацаагаар оршин суух эрхийн гэрчилгээ, үнэмлэх зэрэг биеийн байцаалтыг хэлнэ. Мөн таны шашин эсвэл угсаатны бүлэг, мэргэжил эсвэл улс төрийн бүлэг, холбооны гишүүнчлэл, таны бэлгийн хандлага, эсвэл өөр ашиг сонирхолын байгууллага, бүлэг, нийгмийн гишүүн мөн болохыг баталгаажуулах биеийн байцаалтыг хэлнэ. Хэрвээ та ВОС /нэхэмжлэлдээ өөрийгөө хэн болохыг баталгаажуулах ямарваа нэг биеийн байцаалт хавсаргаж чадаагүй бол яагаад ийнхүү бүрдүүлж чадаагүйгээ шүүх хуралд дэлгэрэнгүй тайлбар өгөх үүрэгтэй.

Та биедээ биеийн байцаалтгүй, эсвэл таны биеийн байцаалтыг хуурамч биш гэдгийг шалган тогтоох шаардлагатай гэж Канадын Хилийн Үйлчилгээний Агентлаг (CBSA) үзвэл таныг саатуулагдана.

Нотлох баримтын зарим жишээ:

- Та тухайн улс орны иргэн мөн болох эсэхийг нотлох баримт: паспорт, иргэний үнэмлэх, цэргийн алба хаасан эсвэл гэрлэлтийн гэрчилгээ, боловсролын гэрчилгээ, диплом.
- Та аливаа нэг шашны нийгэмлэгийн жинхэнэ гишүүн мөн эсэхийг нотлох баримт: баптисмын сертификат, нийгэмлэгийн тэргүүний тодорхойлолт захидал.
- Таны улс төрийн нам эсвэл мэргэжлийн салбарын харъяалалыг нотлох баримт: гишүүнчлэлийн үнэмлэх, байгууллагын албан тодорхойлолт, мэргэжил эзэмшсэн гэрчилгээ, диплом.
- Таны бэлгийн хандлагын онцлогийг нотлох баримт: ижил ашиг сонирхолын бүлгийн, бэлгийн партнёр эсвэл гэр бүлийн гишүүний тодорхойлолт. Эдгээр мэдүүлэг гаргаж байгаа хүн/хүмүүс таныг тухайн цөөнхийн бүлэгт хамааралтай эсэхийг яагаад, яаж мэддэгээ дэлгэрэнгүй бичих шаардлагатай.



Миний нотлох баримтууд:



Итгэл Үнэмшил

Танд тохиолдсон явдал үнэн гэдгээ та IRB-RPD-нд харуулах үүрэгтэй. Таныг үнэнийг хэлж байгааг нягтлахын тул IRB-RPD-ны зүгээс таны хавцаст хэргийн мэдээлэл, шүүх хуралд өгсөн ам мэдүүлэг, хүний эрхийн талаарх мэдээ тайлан болон хөндлөнгийн гэчийн мэдүүлэг зэргийн хоорондын уялдаа холбоог хянан шалгаж харьцуулж үзнэ. Та тодорхой тайлбар өгч чадахгүй мэдээлэл хоорондын зөрчил, авцалдаагүй баримт гарвал IRB-RPD-ны зүгээс таныг итгэл үнэмшилгүй гэж үзэх магадалтай. Таны түүх үнэн бодитой зүйл гэдгийг нотлох баттай баримт бүрдүүлж чадвал таны итгэл үнэмшлийн үнэлгээ өснө. Харамсалтай нь бусдын гэлтгүй өөрийн амьдралын тэр болгон нарийвчлалыг бид байнга санаад байдаггүй. Хэрвээ та хуралдаа гэрч оролцуулж байгаа бол мэдүүлэг өгөх гэдгээ таны нэхэмжлэлтэй холбоотой ям зүйлийг яагаад гэрчлэх хэрэгтэй байгаагаа урьдчлан тайлбарлаг өгсөн байх хэрэгтэй. Яалангуяа IRB-RPD-ны гишүүн танд өгөх итгэл үнэмшлийн үнэлгээгээ нягтлахын тул таны өгсөн мэдүүлэг болон гэрчийн өгөх мэдүүлэгийн

хооронд зөрчил байгаа эсэхийг шинжлэн шалгах болно гэдгийг гэрчдээ сайн ойлгуулаарай.

Нотлох баримтын жишээ:

- Таны түүхэнд өгүүлэгдсэн хүний эрхийн зөрчлийн асуудлын нөхцөл байдал нь улс орны тайлан мэдээнд тусгагдсан мэдээлэлтэй ижил төстэй, эсвэл баталгаажуулах агуулгатай.
- Эмнэлэг/эрүүл мэндийн өвчтний түүх эсвэл үйлчилгээ үзүүлсэн баримт.
- Цагдаагийн тодорхойлолт.
- Гэмтэл бэртийг харуулсан гэрэл зураг.
- Батламж бүхий эрчийн мэдүүлэг.
- Таны гэмтэл, шарх соривийг шинжилсэн Канад дахь эмчийн үзлэгийн тодорхойлолт.



нотлох баримт:



Субъектив айдас

“Цагаачлалын конвенци”-ийн шаардлагад нийцэхийн тул танд өөрийн улс оронд бодитой дарамт заналхийлж байгаа гэдгээ та нотлох үүрэгтэй. Таны айдас бодитой эсэхийг нягтлан шалгах үүднээс IRB-RPD танд дараад агуулга бүхий асуултыг тавьна:

- Танд чигэлсэн дарамтаас зайлсхийж оргосон улс орнодоо эргэн очиж байсан уу?
(эрх зүйн ойлголт: *re-availment*)
- b. Канадад ирэх замдаа дамжин өнгөрсөн танд аюулгүй улс оронд (жишээ нь АНУ) цагаачлах нэхэмжлэл гаргаагүй үү?
(эрх зүйн ойлголт: *Өөр улс орны хүлээн зөвшөөрөөгүй нэхэмжлэл*)



- c. Танд тохиолдсон дарамтын дараа та улс орноосоо оргон явах боломж байсаар байхад та тэндээ үргэлжлүүлэн амьдарсаар байсан уу?

(эрх зүйн ойлголт: *хоцорсон аялалын төлөвлөлт*)

- d. Та Канадад ирснээсээ хойш цагаачлалын нэхэмжлэл гаргах хүртлээ хэсэг хүлээсэн үү?

(эрх зүйн ойлголт: *хоцорсон нэхэмжлэл*)

Эдгээр асуултуудын аль нэгэнд нь та тийм гэсэн хариулт өгсөн тохолдолд шүүх хуралд дээр яагаад тэгэж хариулсан шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай болно. Хариултаа нотлох баримтаар баталгаажуулаарай. Гаргасан шийдвэрээ хэрхэн зөв тайлбарлахаа сайтар бодоорой.

Танд асуудал тулгарсан даруйд улс орноосоо гараагүй, эсвэл цагаачлалын нэхэмжлэлээ цаг алдалгүй гаргаагүйн шалтгаанаа та шүүхэд тайлбарлах үүрэгтэй. Танай улс орны нөхцөл

байдал сайжирна гэж найдаж байсан уу? Улс орондоо амьдрахдаа ямар хүнд бэрхийг туулсан? Канадад ирэнгүүтээ нэхэмжлэлээ яагаад гаргаагүй?



Миний нотлох баримт:

Тодорхой аюул

Танд заналхийлэх аюул бол маш тодорхой, зөвхөн танд, хувь хүнд чиглэсэн асуудал бөгөөд энэ нь танай улс ороны бусад хэн нэгэнд учирч болох нийтлэг аюул/эрсдлийн нэг биш гэдгээ та нотлон харуулах үүрэгтэй. Энэ нь та нийгмийн элдэв хүчирхийлэлийн хив шинж ихтэй улс орноос ирсэн бол, танд тулсан аюул юугаараа онцлог, тодорхой болохыг та дэлгэрэнгүй тайлбарлах үүрэгтэй гэсэн үг.

Та иргэний дайн дажинтай улс орноос ирсэн бол иргэний дайны үеэр шахалт, дарамтын аюулаас дүрвэгсдэд зориулсан IRB-ийн гарын авлагыг www.irb-cisr.gc.ca цахим хаягаар орж (“civilian facing persecution” гэж хайлт хийх) хүн ам олноороо аюулд тулгараад байгаа нөхцөлд оргонол, хамгаалал хүсэх эрхээ хэрхэн хүсэмжлэх вэ гэдгийг уншиж ойлгоход тустай.

Эрүүгийн гэмт хэргийн бүлэглэлийн талаас заналхийлсэн хүчирхийлэлээс танд учирсан тодорхой айдас байгаа бол UNHCR –ээс эрхлэн гаргасан “Зохион байгуулалттай бүлэг гэмт хэргийн хохирогчдод зориулсан цагаачлалын нэхэмжлэл гаргах тухай хөтөч”-ийг

www.refworld.org цахим хаягаар орж (“refugee claims victims of organized crime” гэж хайлт хийх) мэдээлэл аваарай.

Нотлох баримтын жишээ:

- Танд хүч хэрэглэхээр сүрдүүлсэн, заналхийлсныг харуулах бичлэг, гар утасны мессеж зэрэг байж болно.
- Та өөрөө, эсвэл тантай ижил төстэй нөхцөл байдлын хохирогч болсон өөр хувь хүний гэрчлэх батламжилсан гэрчийн мэдүүлэг.
- Таны шарх сорив эсвэл гэмтлийг харуулсан зураг, танай улс орны эмчийн акт, өвчтний түүх, цагдаагийн бүртгэл, тэмдэглэл.
- Танд тулгарсан тодорхой/бодит аюулыг нотлох бусад баримт, мэдээ мэдээлэл.



Миний нотлох баримт:

Төрийн хамгаалал

Танай улс орны төрийн зүгээс таныг хамгаалж чадахгүй эсвэл хамгаалахгүй гэдгийг та IRB-RPD-д батлан харуулах үүрэгтэй. Таныг хамгаалах нь танай төрийн үүрэг гэж үзэх IRB-RPD-ийн байр суурийг өөрчлөхийн тул та хөдлөшгүй, бодит нотлох баримт бүрдүүлэх хэрэгтэй.

Та улс орныхоо эх баригчдаас хамгаалалт хүссэн ч тэд таныг хамгаалаагүй бол:

- Хамгаалалт хүсэмжлэхдээ та ямар арга хэмжээ авсан, түүнд ямар хариу авсан
- Та хамгаалалт хүсч хөөцөлдсөнийг батлах баримтаа цуглуулу
- Таныг, таны нөхцөл байдалд байгаа хэн нэгнийг эрх баригчдын зүгээс хамгаалахгүй эсвэл хамгаалах боломжгүйг харуулах аливаа баримтыг олж авахыг хичээ

Та улс орныхоо эх баригчдаас хамгаалал хүсч хандаагүй тохиолдолд:

- Яагаад хандаагүй гэдгээ тайлбарлаж, танд тэгэж хандах нэмэргүй, үндэслэлгүй байснаа нотлох баримт бичгээ бүрдүүл

Нотлох баримтын жишээ:

- Цагдаагийн байгууллагын үйлчилгээ хүртээмж муутай, мөн/эсвэл авилгад өртсөн байдлыг нотлох улс орны холбоотой тайлан мэдээ
- Та цагдаад гаргасан өргөдөл, бусад баримт бичиг
- Эрх баригчдад хүсэлт гаргасан ч хамгаалалтанд орж чадаагүй тантай ижил төстэй нөхцөлд байгаа/байсан хүний батламжилсан гэрчийн мэдүүлэг



Миний нотлох баримт:



Дотоодын оргонолын хувилбар/сонголт

Таныг улс орныхоо өөр газар нутагт аюулгүй амьдрах боломжтой гэж IRB-RPD-ны зүгээс үзвэл таны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно.



Энэ асуудлыг танд шүүх хурал дээр танилцуубал IRB-RPD-ны зүгээс таны аюулгүй амьдран суух тодорхой газар нутгийн нэр усыг зааж өгнө. Тийм тохиолдолд та дараах байдлыг нотлох хэрэгтэй болно:

а. Та заасан тухайн газар нутагт аюулгүй амьдрах боломжгүй, эсвэл

б. Танд заасан тухайн газар нутагт танд амьдран суух үндэслэл байхгүй (таны нас, хүйс, эсвэл өөр бодит шалтгааны улмаас)

с. Танд заасан газар нутаг дайн дажин, байгалийн гамшигт нэрвэгдсэн эсвэл өөр шалтгааны улмаас хүн амьдрах нөхцөлгүй тул танд тэнд очиж амьдрах ямар ч нөхцөл боломж байхгүй.

Нотлох баримтын жишээ:

- Танд тулгарсан асуудлаас холдохын тул та оршин суугаа газраа өөрчилсөн гэдгээ батлах баримт
- Танд заналхийлсэн хүмүүсийн холбоо сүлжээ улс орны өнцөг булан бүрт байдаг, таны онцлогийг ялгаварлан гадуурхагдах шалтгаан болгосон үзэл баримтлал улсын хэмжээнд тархмал тул та улс орныхоо хаана ч явсан танд аюул учирсан хэвээр байх болно гэх нөхцлийг нотлох тайлан мэдээ, баримт
- Та болон таны ижил төстэй нөхцөлд байгаа

хүмүүс т танай улс орны хаана ч амьдарсан ижил дарамттай гэдгийг харуулсан танай улсын тухай гадаадын тайлан мэдээ. Жишээлбэл энэ нь таны улс орны нийгмийн соёлтой холбоотой

болохыг харуулсан баримт. Үүнээс гадна танд тусгайлан заасан газар нутаг иргэний дайнд, байгалийн гамшиг эсвэл бусад ноцтой асуудалд нэрвэгдснийг та нотлон харуулж болно.

Анхаарах: Тухайн газар нутагт танд ажлын байр олдохгүй эсвэл танд тэнд танил байхгүй гэх хариулт хангалтгүй болохыг анхаарах. Эцсийн эцэст Канадад цагачлахаар ирж байгаа ихэнх дүрвэгчид тус улсад танил талтгүй бас бэлэн ажлын байргүйг бодолцох. Тиймээс илүү үнэмшилтэй, хүлээн зөвшөөрхүйц шалтгааныг өгөх хэрэгтэй.

Миний нотлох баримт:

Өөрийн улс орноос ганда хоёрдогч улсын харъяалал

Та нэг бус улсын иргэншлийн харъяалалтай эсвэл урт хугацаагаар оршин суух эрхтэй бол та тэдгээр улс оронд аль алинд нь амьдрахоршин суух аюултай гэдгээ харуулах үүрэгтэй. Таны иргэншлийн харъяат улс, оршин суух эрхтэй улс аль алинд нь танд амьдран суух аюултай болохыг нотолсон тохиолдолд танд Канадад дүрэвхийг зөвшөөрнө. Хэрвээ та тэдгээр улс орныхоо аль нэгэнд нь аюулгүй амьдрах нөхцөл боломж байгаа гэж үзвэл танд Канадын оргонолыг зөвшөөрөхгүй.

Нотлох баримтын жишээ:


- Та нэгээс дээш улс орон амьдарн суух эрхтэй атлаа танд аль алинд нь аюулгүй амьдрах нөхцөл боломжгүй байж болно. Танд тулсан

эрсдлийг улс тус бүрээр дүгнэж тайлбараа аль болох олон нотлох баримтаар баталгаажуулах.

- IRB-RPD таныг эрх бүхий аль нэгэн улс орондоо аюулгүй амьдрах оршин суух боломжтой гэж үзсэн ч та эсэргүйцэх эрхтэй. Хэрвээ танд хоёрдогч улс орны иргэншил эсвэл амьдран суух эрхтэй байсан боловч таны эрх цуцлагдсан бол тухайн орны төрийн байгууллагаас таны амьдрах оршин суух эрх хүчингүйд тооцогдсон гэдгийг баталгаажуулсан албан тодорхойлолт авах хэрэгтэй.
- Та аливаа хоёрдогч улс оронд төрсөн нь үнэн боловч тухайн улс орны иргэншлийг авч байгаагүй бол тухайн улсын Иргэний тухай хуулийг IRB-RPD-д харуулах хэргэтэй. (Холбогдох мэдээллийг интернетээс авах боломжтой).

Миний нотлох баримт:

Нотлох баримтаа хүлээлгэн өгөх



Та нотлох баримтуудаа Англи эсвэл Франци хэлээр орчуулж шүүх хурал болох өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө IRB-RPD-нд хүлээлгэн өгсөн байх үүрэгтэй. Хэрвээ та өмгөөлөгчтэй бол өмгөөлөгч таныг төлөөлж баримтуудыг хүлээлгэн өгч болно. Баримтуудаа эцэлсэн байдлаар IRB-RPD-нд хүлээлгэж өгөхөөс өмнө өмгөөлөгчөөрөө хянуулж, чанарын шаардлага хангасан орчуулгыг хийсэн байх ёстойг анхаарна уу. Та өмгөөлөгчгүй бол дараа хуудсан дахь зөвлөмжийн 1-10 алхамуудыг даган гүйцэтгээрэй.

Танд гэрчийн мэдүүлэг өгсөн гэрчийн нэр/нэрсийг та шүүх хурал болохоос 10 хоногийн өмнө IRB-RPD-нд өгсөн байх үүрэгтэй. Гэрчийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 34, 37 дугаар хуудаснаас харна уу.

Хуулийн эцэсийн хугацааг алдаж болохгүй!

Та нэхэмжлэлийн нотлох болон бусад дэмжих баримт бичгийг хүлээлгэн өгөхдөө дараах алхамуудыг дагаарай:

1 Баримтуудаа Англи/Франц хэлээр орчуулсан байх ёстой. Баримтын орчуулга бүрт орчуулагчийн доорх мэдээлэл бүхий батламжийг хавсаргасан байх ёстой:

- Орчуулагчийн нэр, гарын үсэг
- Орчуулгын эх хэл болон хэлний аялгуу
- Орчуулга үнэн зөв гэх орчуулагчийн баталгаа

2 Баримт бичиг 22x 28 см-ийн хэмжээтэй А4 цаасан дээр буулгасан байх ёстой. Баримтын үг үсгийн хэмжээ 12 фонтоос багагүй байх ёстой.

3 Баримтуудыг багцлаж эхний хуудсаас эцсийн хуудас хүртэл дугаарлах (1,2,3,4,5...).

4 Өөрийн нэр, оршин суугаа хаяг, огноо, IRB-RPD дахь таны хавцаст хэргийн дугаар, хавцсанд орсон баримт бичгийн жагсаалт тэдгээрийн хуудсын дугаар зэрэг мэдээллийг нүүр хуудсанд бич.

5 Багцалсан баримтын хуулбарыг 2 хувиар бэлд. (нэг хувийг та IRB-RPD-нд хүлээлгэж өгнө, үлдсэн хувийг та өөртөө өвч үлднэ).

6 Таны шүүх хуралд (CBSA эсвэл CIC төлөөлөн) Minister's Counsel оролцох бол багц баримтын нэг хуулбарын түүнд зориулж бэлдэж өгөх хэрэгтэй. Minister's Counsel шүүх хуралд оролцох эсэхээ хурлаас 10 хоногийн өмнө урьдчлан бичгээр мэдэгдсэн байх болно.

7 Боловсруулан бэлэн болгосон багц баримтын нэг хувийг буухиа шуудангаар IRB-RPD-нд илгээ. Хэрвээ ердийн шуудангаар явуулах гэж байгаа бол хугацаагаа тавиу тооцоолж шүүх хурал болох өдрөөс наанадаж 17 хоногийн өмнө явуулаарай. Таны багц баримт IRB-RPD-нд шүүх хурал болхоос 10 ХОНОГИЙН ӨМНӨ хүргэгдсэн байх ёстой. Таны баримт 20-иос доош хуудастай бол та баримтуудаа факсаар илгээж болно.

IRB-RPD
300 West Georgia Street, Suite 1600
Vancouver, BC V6B 6C9
Утас: 1-866-787-7472 Факс: 604-666-3043

Даваа – Баасан гаргуудад: 08:00-16:00

8 Буухиа шуудангаар явуулж байгаа бол үйлчилгээний баримтаа аваарай. **Факсаар** явуулж байгаа бол факс амжилттай дамжуулагдсаныг нотлох баримтаа заавал аваарай.

9 Таны шүүх хуралд Minister's Counsel оролцохоо мэдэгдсэн бол түүний төлөөлж байгаа CBSA эсвэл CIC-нд багц баримтынаа хуулбарыг явуулаарай. Төлөөлөх байгууллагын нэр танд бичгээр ирэх Хөндлөнгийн оролцооны мэдэгдэл (Notice if Intervention) дээр заасан байх болно. Мөн CBSA эсвэл CIC-нд багц баримтаа хүргүүлсэн гэдгээ та IRB-RPD-нд мэдэгдэх захидал явуулаарай.

10 Та нэхэмжлэлд хавсаргасан болон холбогдох баримтуудынхаа бүх эх болон хуулбар баримтыг шүүх хуралдаа авчраарай.



Бичиг баримтаа би заавал мэргэшсэн орчуулагчаар орчуулуулах ёстой юу?

Заавал биш, тэгэхдээ мэргэшсэн байвал бүр сайн. Танд мэргэшсэн орчуулагчийн хөлсийг төлөх боломжгүй бол орчуулгыг таны итгэл бүхий хүнээр (садан төрөл биш бол сайн) хийлгэж болно. Орчуулсан хүн мөн орчуулагчийн батламж гаргаж өгөх үүрэгтэй.



Хуулийн эцэсийн хугацаанаас өмнө эсвэл шүүх хурлаас өмнө онц чухал баримтаа гар дээрээ авч амжаагүй бол яах вэ?

IRB-RPD-д бичгээр мэдэгд. Баримтаа хүлээн авангуутаа IRB-RPD-д хүргүүлээрэй. Яагаад тухайн баримт онц чухал болох, мөн тус баримтыг гар дээрээ олж авахын тул та ямар арга хэмжээ авсан эсэхээ тайлбарлаарай.

Шүүх хуралд бэлдэх хугацаанд та эрүүл байх нь чухал

// Шүүх хурал болтол би их санаа зовж унтаж чадхаа байсан.
Хүлээлт миний хувьд их стресстэй байсан. //

— Саман, цагаачлалын нэхэмжлэгч асан



Олон хүний хувьд шүүх хурлаа хүлээх хүлээлт их хүнд тусдаг. Эрүүл байхын тул нэхэмжлэгчид юу хийж байсан талаар зарим жишээг уншаарай.

“Би аль болох тайван байхыг хичээж миний асуудал бүтэмжтэй байх болно гэж боддог байсан.”

- Ахмед

“Надад тохиолдсон явдлаа аль болох нарийвчлан санахыг хичээсэн, бодох тусам илүү ихийг санаж эхэлсэн”

- Бенойт

“Би шүүх хуралд дээр хүнд хэцүү асуултанд хариулж байгаагаар өөрийгээ төсөөлөн боддог байсан.”

- Мария

“Би тогтмол залбирал үйлдэж тайван байдлаа хадгалдаг байсан.”

- Чэн Жин Юи

“Би хөгжим сонсч ном уншдаг байсан”

- Мэдин

“Би ар гэрийнхэнтэйгээ Skype-р холбогддог байсан”

- Мохамед

“Би болж өгвөл завгүй байхыг хичээж Англи хэлний сургалтанд хамрагдаж бас олон нийтийн уулзалтанд очдог байсан”

- Давид

“Би нэхэмжлэлдээ нэмэр болох аль болох олон нотлох баримт цуглуулах гэж их чармайсан. Их чухал хэрэгцээтэй юм хийж байгаа мэт сэтгэгдэл төрдөг байсан.”

- Клауди

“Би усанд сэлж эсвэл ямар нэг дасгал хийдэг байсан”

- Виктория

“Би сайн дурын ажил олж хийгээд ажилдаа завгүйдээ сэтгэл санаагаа тогтвортой байлгаж байсан”

- Тесфае

“Шүүх хурлын явц болон бусад мэдээллийг сонирхож вэбсайт их уншиж суудаг байсан”

- Жагадрагаван

“Би гадуур гардаг байсан. Ганцаараа байхлээр хит ганцаардан гиоурч болсон явдлын талаар элдэв юм бодогдоод байдаг байсан.”

- Ханна

“Алхаж явах зуураа би асуултанд хэрхэн хариулахаа бэлддэг байсан”

- Сара



Эрүүл байхын тул миний хийх зүйл:

Таны шүүх хурлын өдөр

Таны цагаачлалын эрх хүсэмжилсэн нэхэмжлэлийг хэлэлцэх шүүх хурал бол нэхэмжлэл гаргах үйл явцын хамгийн онцгой үйл явдал. Энэ өдөр танаас төлөвлөж байснаас тань илүү олон асуулт асууж магад.

Миний шүүх хурал хаана болох вэ?

Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл - Цагаачдын эрх зүйн байдлыг Хамгаалах Хорооны байранд
Immigration and Refugee Board – Refugee Protection Division
225 Manning Road NE, Suite 201
Calgary, Alberta

Би хэдийд нь очсон байх ёстой вэ?

Товлогдсон шүүх хурал эхлэхээс багаар бодход 15-30 минутийн өмнө. Хурлын танхимаа олох, орчуулагчтайгаа харилцан ярилцаж бие биенийхээ хэл яриаг сайн ойлгож байгаагаа шалгаж, ариун цэврийн өрөөнд орох бусад шаардлагатай бэлтгэлийг хангахад хэрэгтэй. Хэрвээ таны шүүх хуралд гэрч, ажиглагч оролцож байгаа бол тэдгээр нь хурал эхлэхээс 15 мин өмнө ирсэн байх ёстой.

Миний шүүх хуралд хэн хэн оролцох вэ?



Presiding Member

буюу Тэргүүлэх Гишүүн

(Оролцооны үүрэг: Шийдвэр гаргагч. Тэргээр шүүх хуралд видеогоор холбогдон өөр газраас оролцох тохиолдол гардаг)

Орчуулагч

Шаардлагатай тохиолдолд оролцно (Оролцооны үүрэг: дундын байр суурийг хадгална)

Minister's Counsel

буюу Сайдын Төлөөлөл

Зарим тохиолдолд CBSA эсвэл CIC-ыг төлөөлж шүүх хуралд оролцдог. Оролцох эсэхээ урьдчлан мэдэгддэг. (Оролцооны үүрэг: Таны эсрэг маргаан үүсгэнэ)

Өмгөөлөгч

(Оролцооны үүрэг: Таныг өмгөөлнө. Танд өмгөөлөгч байхгүй бол 9-р хуудсыг унш)

Таны бие

Ажиглагч
Та шүүх хуралдаа найз болон гэр бүлийнхээ гишүүнийг оролцуулж болно. Шаардлагатай тохиолдолд UNHCR-ийн төлөөлөгч таны хуралд оролцно.

Хурал хэр удаан үргэлжлэх вэ?

Ихэвчлэн 3.5 цаг үргэлжилдэг. Хуралд гэр бүлийн гишүүн оролцох бол эсвэл танд тусгай нөхцөл шаардагддаг бол шүүх хурал бүтэн өдөр үргэлжлэхийг үгүйсгэхгүй.

Хурал дээр яг юу болдог бэ?

1. Танилцуулга: Хуралд оролцогчдыг мөн хурлын дэгийг Presiding member танилцуулна. Та зөв үнэний тангарга өргөнө. Өөрийн шашны Ариун Сударт тангарлахыг хүсвэл та судар номоо хуралд авчирч болно.
2. Хавсралтын жагсаалт: Нотлох баримтанд бүртгэгдсэн бичиг баримтыг хавсралтын дугаарыг Presiding member танилцуулна. Танилцуулсан жагсаалын дагуу баримтууд танд байгаа эсэхийг шалгаж дутуу баримт байгаа тохиолдолд Presiding member- с хуулбарыг аваарай. Мөн тэрбээр таны бэлдэн авчирсан бусад эх баримттай танилцна.
3. Асуулга: Presiding member, Minister’s Counsel (оролцох тохиолдолд), өмгөөлөгч (байгаа тохиолдолд) гэсэн дарааллаар таны түүхтэй болон нэхэмжлэлд холбогдох асуултыг танд тавьна.
4. Гэрч: Хэрвээ хуралд гэрч оролцож байгаа бол тэд асуулгын дараа мэдүүлгээ өгнө. Гэрчийн мэдүүлгийг сонсох гэж дуудагдахаас нааш гэрч хурлын танхимд байх эрхгүй, гадна нь хүлээнэ.
5. Санал шүүмж: Шүүх хурлын төгсгөлд Presiding member танд эсвэл таны өмгөөлөгчид “Цагаачлалын Конвенци” эсвэл “Хамгаалалын Этгээд”-ийн шаардлагыг та бүрэн хангаж байгаагаа баримтаар нотлон санал бодлоо илэрхийлэх боломж өгнө.
6. Шийдвэр: Presiding member хурлын төгсгөлд шүүхийн шийдвэрээ амаар гаргаж болно, эсвэл шийдвэр гаргахад хугацаа шаардлагатай гэж үзвэл шийдвэрийг бичгээр хүргүүлэхээ танд мэдэгдэж болно. “Шүүхийн шийдвэр” мэдэгдлийг аливаа тохиолдолд танд шуудангаар хүргүүлнэ.

Шүүх хурлын явцад богино завсарлага гардаг тул завсарлагаар та ус/цай уух, ариун цэврийн өрөө орох боломжтой.

Миний шүүх хуралд CBSA эсвэл СІС-ийг төлөөлж Minister’s Counsel оролцно гэвэл юу гэж ойлгох ёстой вэ?

Шаардлагатай тохиолдолд CBSA эсвэл СІС-ийн төлөөлөл таны шүүх хуралд оролцно. Шүүх хурлаас өмнө Хөндлөнгийн оролцогчийн мэдэгдэл та хүлээж авсан бол таны хуралд Minister’s Counsel оролцох юм байна гэж ойлгох хэрэгтэй. Тус мэдэгдэлд Minister’s Counsel хуралд биечлэн оролцох эсвэл албан бичиг хүргүүлэх эсэхээ тодорхой заасан байна. Мэдэгдлийг МАШ АНХААРЛАЙ УНШ – тэрбээр баримтанд үндэслэн таны түүх үнэнд нийцэхгүй гэх маргаан үүсгэх гэж байгаа байж болно.

Minister’s Counsel таны хуралд оролцохоо мэдэгдсэн бол таныг цагаачлалын эрх эдлэх эрхгүй гэсэн байр сууринаас шүүх дээр таны эсрэг маргаан үүсгэнэ. Таны эсрэг маргаан үүсгэх нь дараах шалтгаантай байж болно: таныг худал мэдүүлэг өгсөн, таны биеийн байцаалт болон таны жинхэнэ харъяалалд эргэлзээтэй, таныг гэмт хэрэгт эсвэл таныг ямарваа нэг террорист үйл ажиллагаа/ байгууллагатай холбоотой болон бусад шалтгаан. Ямар шалтгаанаар Minister’s Counsel шүүх хуралд оролцох болноо урьдчлан тайлбарлаагүй бол та тодруулга авах эрхтэй.

Шүүх хуралдаа би ямар бичиг Баримт авчрах ёстой вэ?

Хуралд ирэхдээ та өөрийн ВОС/нэхэмжлэл, танд байгаа биеийн байцаалтуудаа болон CBSA, CIC болон IRB-RPD- нд бүрдүүлж өгсөн бүх нотлох баримтын эх хувийг авчирна. Мөн Канадад ирснээсээ хойш улс орноосоо хүлээн авсан төрийн байгууллагын холбогдол бүхий бичиг баримтуудыг авчирсан байх хэрэгтэй.

Миний шүүх хурал нууцын баталгаатай юу?

Цагаачлалын асуудал шийдвэрлэх бүх шүүх хурлууд нууцын баталгаатай. Энэ нь тус шүүх хуралд оролцогчид болон орчуулагчид ижил хамаарна, таны хувийн болон шүүх хурлын холбогдолтой аливаа мэдээллийг чандлан нууцлах үүрэгтэй.

Орчуулагчийн яриаг би ойлгоогүй, эсвэл орчуулагч буруу орчуулаад байна гэж бодогдвол би ях ёстой вэ?

Орчуулагчийн яриа бүрэн ойлгомжгүй эсвэл орчуулагч шүүх хурлын үеэр агуулгын алдаа гараад байна гэж та үзвэл үүнийгээ шийдвэр гаргагчид мэдэгдэх хэрэгтэй. Ажиглагчийн зүгээс орчуулагчийн ийнхүү алдааг олж харвал хурлын завсарлага, эсвэл хурлын төгсгөлд гарсан алдааг таны өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй. Орчуулагч таны яриа, илэрхийлсэн бодол санааны агуулгад найрууллагын алдаа гаргасан тохиолдолд та хэлсэн бүхнээ дахин давтаж, шаардлагатай бол өөр үг хэллэгээр санаагаа илэрхийлж орчуулгыг өөрийн санаандаа бүрэн нийцүүлэх хэрэгтэй. Орчуулга таны санаанд нийцэхгүй бол үүнийгээ Presiding Member-т мэдэгдэх эрхтэй.

Би шүүх хуралдаа гэрч оролцуулж болох уу?

Болно. Таны гэрч тус хуралд биечлэн, утасаар эсвэл шууд дамжуулах видеогоор шүүх хуралд оролцож болно. Хуралдаа гэрч оролцуулах хүсэлтээ та IRB-RPD-нд шүүх хурлаас 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байх хэрэгтэй. Ийнхүү мэдэгдэхдээ та IRB-RPD (оролцох тохиолдолд Хуулийн зөвлөхөд мөн адил)-нд гэрчтэй холбоо барих хаяг, утасны дугаар, гэрч танд ямар хамааралтай болох (гэр бүлийн гишүүн, найз, олон нийтийн байгууллагын гишүүн), хуралд биечлэн оролцох эсвэл утасаар мэдүүлэг өгөх эсэх, тухайн гэрчийн мэдүүлэг таны нэхэмжлэлд ямар ач холбогдолтой болох, гэрчийн мэдүүлэгт шаардагдах хугацаа талаар мэдээллийг өгөх үүрэгтэй. Хэрвээ та хуралдаа мэргэжлийн шинжээч оролцуулах хүсэлтэй байгаа бол тухайн шинжээчийн мэргэшлийн талаар мэдээллийг холбогдох газар өгнө. Гэрч хуралд биечлэн оролцож байгаа бол мэдүүлгээ өгөхөөр дуддагдах хүртэл хурлын танхимын гадна байна. Гэрч утасаар мэдүүлэг өгөх бол та утасны урьдчилсан төлбөрийн картаа шүүх хуралд бэлдэн авчирна.

Би найз нөхдөө оролцуулж болох үү?

Болно. Хэрэгт холбогдолтой чухал баримт, мэдээ мэдээлэлтэй байсан ч таны найзууд гэрчээр албан ёсоор бүртгүүлэхээс нааш шүүх хуралд мэдүүлэг өгөх, саналаа хэлэх эрхгүйгээр оролцож болно. Шүүх хуралд хүрэлцэн ирэхдээ таны найзууд хурлын нууцлалыг чандлан сахих баталгааны маягтанд гарын үсэг зурна.

Надад “хүчингүйд тооцох” гэж мэдэгдвэл би ямар ойлголттой байх ёстой вэ?

IRB-RPD таныг өөрийн улс оронд бодит аюултай тулгараад байгаа хэдий ч танд цагаачлалын оргонол олгох үндэслэлгүй гэж үзэж байна гэж ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, таны нэхэмжлэлийг хүчингүйд тооцох шалтгаан нь та Канадын хилийн чандад ноцтой гэмт хэрэгт холбогдсон гэдэг нь тогтоогдсон, эсвэл танд өөр нэгэн улс оронд аюулгүй амьдрах, бусад иргэний адил тэгш эрхтэй байх боломж байгаа гэж үзсэнтэй холбоотой байж болно. Хэрвээ таны нэхэмжлэлийг хүчингүйд тооцох талаар хэлцэх гэж байгаа бол үүнийг хурал эхэлхээс өмнө танд мэдэгднэ. Тус хурлаар IRB-RPD таны нэхэмжлэлийг хүчингүйд тооцох талаар хэлцнэ гэж мэдэгдвэл та эсэргүйцэл гаргах нотлох баримт цуглуулах хугацаа авч тус хурлыг завсарлаж хойшлуулах (өөр өдөр товлох)-ыг шаардах эрхтэй.

Шүүх хуралд би Хүүхдүүдээ дагуулж ирэх шаардлагатай юу?

Таны цагаачлалын нэхэмжлэлд хавсрагдсан бага насны хүүхэд байгаа тохиолдолд та шүүх хуралд хүүхдээ биечлэн байцуулж танилцуулах ёстой. Танилцсаны дараа таны хүүхдүүдийг шуух хурлын танхимаас гархыг хүсэмжлэх байх. Тиймээс шуух хурлын үеэр таны хүүхдийг харгалзах хүн дагуулж ирээрэй.

Хувцаслалт ямар байх ёстой вэ?

Шүүх хуралдаа та аль болох таны биед тухтай, даруу төлөв хувцаслаарай. Таны хувцаслалт цэвэр цэмцгэр, таны төлөвшил, тухайн шүүх хуралд хандах таны хандлагыг бүрэн илтгэж байх ёстой.

Шүүх хурал дээр дуу Хураах бичлэг хийх үү?

Шүүх хурлын танхимд байрлуулсан микрофон хурлын дуу бичлэгийг хийнэ. Таны нэхэмжлэлд татгалзсан хариу гарсан нь Presiding Member нотлох баримтын үндэслэлийг ойлгоогүйгээс гэж та үзсэн тохиолдолд IRB-ноос хурлын дуу бичлэгийн хуулбарыг авч болно.

Би хурлын үер сэтгэлийн хямралд орж эсвэл уйлвал яах вэ?


Санаа зоволтгүй. Цагаачлалын нэхэмжлэл хэлцэх шүүх хурлын үеэр нэхэмжлэгч уйлах тохиолдол олон гардаг. Хурлын явцад та гэнэт сэтгэлийн хямралд орвол тайвшрах дараах аргуудыг хэрэглэж болно. Жишээлбэл:

- 3–4 удаа урт гүнзгий амьсгалах
- Танд ус авчирч өгөхийг хүсэх
- Богино хугацааны завсарлага авахыг хүсэх



Анхаарах зүйл! Энэ бол ТАНЫ өдөр. Та аль болох тайван, ая тухтай байх нөхцөлөө бүрдүүлэхэд хэрэгцээтэй болгоно хийх хэрэгтэй.

Шүүх хуралд бэлтгэл хангах хяналтын жагсаалт



Шүүх хуралдаа бэлтгэл хангах дараах хяналтын жагсаалтыг ашиглаарай. Та өмгөөлөгчтэй бол хяналтын хуудасаа түүний хамт хянаж шалгаарай.



- Би өмгөөлөгчтэйгөө (өмгөөлөгчтэй тохиолдолд) уулзсан бөгөөд, шүүх хуралдаа бүрэн бэлдхэгдсэн.
- Би баримтуудаа Англи/Франц хэлээр орчуулж шаардагдах биеийн байцаалт болон холбогдох баримт бичиг (албан тоот, видео бичлэг, сонингийн нийтлэл г.м)-ээ IRB-RPD-нд шүүх хурлаас 10 хоногийн өмнө хүлээлгэж өгсөн.
- Баримт хүлээлгэж өгсөнөөс хойш хурал болхоос 10 хоногийн дотор шинээр тохиолдсон аливаа явдал болон шинээр хүлээн авсан баримыг Англи/Франц хэлээр орчуулж холбогдох газар хүргүүлсэн.
- IRB-RPD-с шаардсан тохиолдолд нэмэлт баримтыг тавигдсан шаардлагын дагуу бүрдүүлж өгсөн.
- ВОС/нэхэмжлэлийн мэдээлэл үнэн зөв, бүрэн бүтэн эсэхийг шалган хянаж уншсан. Алдаа, зөрүүтэй мэдээлэлд (алдаа/зөрчил гарсан бол) засвар хийж үүнийг өмгөөлөгчдөө болон IRB-RPD мэдэгдсэн.
- Би “Цагаачлалын конвенци” болон “Хамгаалалд хамрах этгээд”-ийн эрх зүйн тодорхойлолттой (20-21 дүрээг хуудас) уншиж танилцсан бөгөөд миний хэрэгт холбогдох бусад хууль эрх зүйн нэр томёоны талаар (23-27 дугаар хуудас) бүрэн ойлголт авсан.
- Миний цагаачлалын нэхэмжлэлд холбогдох бүх баримт бичиг цэгцлэгдсэн бөгөөд тэдгээрийг шүүх хуралдаа авч очно (биеийн байцаалтын эх хувь, хэрэгт хавсаргасан нотлох баримтын эх хувь, ВОС, CIC-д бүрдүүлсэн баримтын хуулбар, CBSA, CIC мөн IRB-RPD-нд холбогдох баримтын хуулбар).
- Миний шүүх хуралд оролцож биечлэн эсвэл утасаар мэдүүлэг өгөхөө батламжилсан гэрчийн нэр/с, бусад холбогдох мэдээллийг хурал болхоос 10 хоногийн өмнө бүрдүүлж IRB-RPD-нд өгсөн (34 дүрээг хуудас). Оролцох гэрчид хурлын явц болон гэрчийн мэдүүлгийн ач холбогдлыг тайлбарлаж өгсөн. Presiding Member гэрчээс түүний мэдүүлэг миний түүхтэй уялдаа холбоотой, итгэл үнэмшилтэй эсэхийг тодруулан асуулт асууж болзошгүй гэдгийг гэрчид урьдчлан тайлбарласан. Шүүх хурлын огноо, байр, цагийн тухай мэдээллийг гэрчид өгсөн.
- Намайг дэмжих ажиглагч (найз, гэр бүлийн гишүүн, бусад дэмжих хэн нэгэн) шүүх хуралд оролцуулж болно гэдгээ би мэдэж байгаа. Ажиглагч оролцуулах бол шүүх хурал болох огноо, байр, цагийн тухай мэдээллийг түүнд өгсөн.
- Хүүхэдтэй бол хүүхэд харгалзах хүнээ бэлдсэн. IRB-RPD-ны гишүүн миний хүүхдийг шүүх хурлын эхэнд харах шаардлагатай гэдгийг би мэдэж байгаа.
- Би шүүх хуралдаа бэлтгэгдсэн. Эх орондоо буцах айдсаа би тайлбарлах чадвартай болсон бөгөөд асуултанд хариулах бэлтгэлээ өмгөөлөгч, гэр бүлийн гишүүн, эсвэл найзтайгаа хийсэн.



Гэнэтийн нөхцөл байдлын шалтгаанаар шүүх хурлын өдөр эсвэл цагийг өөрчлөх шаардлага гарвал би яах ёстой вэ?

Та эсвэл таны өмгөөлөгч заавал:

- Шүүх хурлаас ажлын 3 хоногийн өмнө IRB-RPD-нд бичгээр мэдэгдэх ёстой
- Хурлын товлогдсон өдрөөс хойш ажлын 10 өдөр дотор боломжтой 3 өдрийнхээ хувилбарыг та IRB-RPD санал болгох ёстой
- Өөрчлөх болсон шалтгаан таны эрүүл мэндтэй холбоотой бол эмчийн магадалгаа, хэрвээ магадалгаа авах боломжгүй бол яагаад авах боломжгүй байсан шалтгаанаа бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Хэрвээ IRB-RPD-ноос хурлын өдрийг өөрчлөх талаар хариу өгөөгүй бол та товлогдсон хугацаандаа хуралдаа биечлэн оролцох үүрэгтэй. Оролцоогүй бол та “Шүүхэд биечлэн оролцох мэдэгдэл”-д заасан хугацаанд “тусгайчилсан шүүх хурал”-д оролцох үүрэгтэй. “Тусгайчилсан шүүх хурал”-аар таны нэхэмжлэлийг “хэрэгсэхгүй” болгох магадалтай. Minister’s Counsel шүүх хуралд оролцохоо мэдэгдсэн бол хурал хойшлуулах хүсэлтийн нэг хувийг түүнд хүргүүлсэн байх үүрэгтэй. IRB-RPD-нд хандах өргөдөлд та хүсэлтээ CIC, CBSA-т хэзээ, хэрхэн хүргүүлсэн эсэхээ мэдэгдэх үүрэгтэй.

Шүүх хурлын дараа



Эерэг шийдвэр:

Шүүх хурлаас таны нэхэмжлэлд эерэг/зөвшөөрсөн шийдвэр гарсан, түүнчлэн хурлаас хойш 15 хоногийн дотор Minister гомдол гаргаагүй бол та Канад улсад байнгын оршин суух эрхийн хүсэлтээ CIC-нд гаргаж болно. Хүсэлт гаргах маягтандаа та өөрийн хууль ёсны эхнэр/нөхөр, хүүхдээ хамруулж болно.

Зарим бүлэг хүмүүсийг Сэжиг бүхий гадаадын харьяат (цаашид DFN гэх)-ад хамруулна. Таныг ийнхүү DFN-д тодорхойлсон бол та байнгын оршин суух эрхийн хүсэлт гаргах хүртлээ 5 жил хүлээх шаардлагатай. Таныг DFN-д хамааралтай гэж CIC үзэх эсэхээ танд шүүх хурлаас өмнө мэдэгнэ (дэлгэрэнгүй мэдээллийг 40 дүгээр хуудаснаас унших).

Өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөхгүйгээр та Канадын нутаг дэвсгэрээс гарч болохгүй. Канадаас өөр улс оронд зорчих зайлшгүй шалтгаан гарсан тохиолдолд та Refugee Travel Document/Цагаачийн Аялалын Баримт бичиг авах ёстой. Тус баримтыг хүсэмжлэх анкетийн маягтыг www.ppt.gc.ca цахим хуудсаар орж “Find a Form” цонхыг сонгож “Travel Document Application” сонголтыг хийгээрэй.

Сөрөг шийдвэр:

Шүүх хурлаас таны нэхэмжлэлд сөрөг/татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд дараах боломжуудаас танд зохих хувилбарыг өмгөөлөгчтэйгээ зөвлөлдөөрэй:

- Сайн дурын үндсэн дээр та Канадаас гарах, эсвэл
- Та давж заалдах эрхтэй бол гарсан шийдвэрийг Цагаачлал, Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл-Цагаачлалын талаар гарсан шийдвэрийг давж заалдах шатны асуудал шийдвэрлэх хороо (цаашид IRB-RAD гэх)-нд давж заалдаж болно, эсвэл
- Та давж заалдах эрхгүй бол Дээд шатны шүүхэд шүүхийн шийдвэрийг хянан хэлцүүлэх хүсэлт гаргаж болно.

Та IRB-RPD шийвэрийг IRB-RAD-нд давж заалдах бол:

- Давж заалдах явц нь их ярвигтай бас цаг хугацаа их шаарддаг тул танд өмгөөлөгчийн туслалцаа авах шаардлагатай. Өмгөөлөгч олох боломжгүй бол 44 дүгээр хуудсанд заасан холбогдох агентлагт хандан туслалцаа аваарай.
- Шүүхийн шийдвэр хүлээн авсан өдрөөс 15 хоногийн дотор IRB-RAD-д хүсэлтээ гаргах эрхтэй. Үүнээс хойших 15 хоногт багтаж “төгс” (бүрэн боловсруулсан) давж заалдах өргөдлөө гаргах эрхтэй.
- Таны давж заалдах өргөдлийн хариу гартал та Канад улсад оршин суух эрхтэй.
- Дийлэнх тохиолдолд, шүүх хурал хуралддаггүй. Таны өгсөн өргөдөл болон шүүхийн шийвэрийг эсэргүүцэх баримтанд үндэслэж давж заалдах шатны шийдвэрийг 90 хоногийн дотор гаргаж танд хүргүүлнэ.
- Таны өргөдөл IRB-RAD татгалзсан хариу өгвөл та Шүүхийн шийдвэрийг хянан үзэх Дээд шүүхэд хандах эрхтэй. Шүүхийн шийдвэрийг хянан үзэх таны хүсэлтийн эцсийн хариу гартал та Канад улсад оршин суух эрхтэй.

Танд IRB-RAD-д давж заалдах эрх байхгүй тэгэхдээ та IRB-RPD-ийн татгалзсан шийдвэрийг эсэргүүцэж Дээд Шүүхэд хянуулахаар хандаж байгаа бол:

- Давж заалдах явц нь их ярвигтай бас цаг хугацаа их шаарддаг тул танд өмгөөлөгчийн туслалцаа авах шаардлагатай.
- Шүүхийн шийдвэр хүлээн авсан өдрөөс 15 хоногийн дотор та Дээд шүүхэд хүсэлтээ гаргах эрхтэй.
- Таныг албадан гаргах үйл ажиллагааг эхлүүлэхээ CBSA-аас мэдэгдсэн бол та үүнийг өмгөөлөгчдөө нэн даруй мэдэгдэх ёстой. Та Шүүхийн шийдвэр хянан хэлэлцэж эцэсийн шийдвэр гарах хүртэл Канад улсад оршин суух эрхээ хадгалахын тул албадан гаргах үйл ажиллагааг “түр хүлээх” (түр зогосоох)-ийг хүссэн өргөдлөө Дээд шүүхэд гаргах шаардлагатай болно.

Дээд шүүхийн хаягийг дараах цахим хуудсаас харж болно:

http://cas-ncr-nter03.cas-satj.gc.ca/portal/page/portal/CAS/locations_eng

IRB-RAD-нд давж заалдах шүүхийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг:

www.irb-cisr.gc.ca/Eng/RefApp/Pages/RefApp.aspx



Би IRB-RAD-нд давж заалдах эрхтэй юу?

Та IRB-RPD-ны татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрч IRB-RAD-нд давж заалдах

хууль ёсны эрхтэй эсэхээ тодорхойлохын тул хуульч/өмгөөлөгчийг оролцуулах нь их ач холбогдолтой.

Танд хуульч/өмгөөлөгч байхгүй бол та хуулийн мэргэжилтнээс, хуулийн ангийн оюутнаас эсвэл тус гарын авлагын 44 дэх хуудсанд заасан үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгдөг товчооноос туслалцаа авах хэрэгтэй.

IRB-RPD-оос DFN-д хамруулсан зарим DCO-ны иргэн цагаачлалын нэхмжлэгчдэд зөрүүтэй мэдүүлэг өгсөн эсвэл хуурамч бичиг баримт ашигласан гэх үндэслэлээр IRB-RAD-нд давж заалдах эрх олгодоггүй.



Давж заалдах болон Шүүхийн шийдвэрийг хянан шалгах хоёр ойлголт ямар ялгаатай вэ?

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр гаргагч нь IRB-RAD-н гишүүн байх бөгөөд тэрбээр таны нэхэмжлэлд шинээр шийдвэр гаргах боломжтой. Шүүхийн шийдвэрийг хянан хэлцэх дээд шатны шүүхийн шийдвэр гаргагч нь Дээд Шүүхийн шүүгч байх бөгөөд тэрбээр танд шүүхийн шийдвэр гаргасан Presiding Member шийдвэр гаргах явцад хууль эрх зүйн алдаа гаргасан эсэхийг хянан шалгана. Шүүгч таны шийдвэрт алдаа гарсан байна гэж үзвэл таны нэхэмжлэлийг анхан шатанд дахин хэлцүүлэхээр IRB-RPD-нд буцаана.

Хэрвээ та давж заалдах шүүхэд хандах эрхтэй бол Шүүхийн шийдвэрийг хянуулах дээд шатанд хандхаас өмнө IRB-RAD-д давж заалдах өргөдлөө гаргаарай.

ТОДОРХОЙЛОЛТ

Хэрэгсэхгүй нэхэмжлэл:

ВОС/нэхэмжлэлээ хүлээлгэн өгөх хуулийн хугацаанаас хоцорвол, эсвэл IRB-RPD-с заралсан шүүх хуралдаа биечлэн оролцоогүй тохиолдолд таны нэхэмжлэлийг “хэрэгсэхгүй”-д тооцно. Энэ нь та нэхэмжлэлээ цаашид үргэлжлүүлэх эрхгүйгээс гадна шинээр нэхэмжлэл гаргах эрхгүй болно гэсэн үг. Таны нэхэмжлэлийг “хэрэгсэхгүй” болговол та нэхэмжлэлээ сэргээн нээлгэх хүсэлт гаргаж болно, гэвч энэ нь тийм амар ялах хэрэг биш.

Тухайлсан улс орон (DCO):

CIC-ны “аюулгүй улс орон”-ны жагсаалтанд орсон улс орныг хэлнэ. (Эдгээр улс ороны иргэд нь цагаачлах шаардлагагүй гэж Канадын Засгийн газраас тодорхойлсон хэдий ч хүний эрхийг хүндэтгэн үзэж онцгой нөхцлийг харгалзан оргонолыг зөвшөөрдөг). Жишээлбэл: АНУ эсвэл Европийн дийлэнх улс орон ордог. Тус улс орны иргэний харьяатын цагаачлалын нэхэмжлэлийг хүлээн авах, хэлцэх бие даасан журамтай. Тухайлсан улс орны нэрсийн жагсаалтыг www.cic.gc.ca цахим хаягаас (“DOC” гэж хайлт хийх) үзээрэй. Тухайлсан улс орны харьяатан IRB-RAD-д давж заалдах эрхгүй, тэгэхдээ Дээд шүүхэд шүүхийн шийвэрийг хянан хэлцүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Мөн эдгээр нэхэмжлэгчдийн асуудлыг харьцангуй хурдсгасан (шуурхай)хуваариар авч хэлцдэг.

Сэжиг бүхий гадаадын харьяат (DFN):

Канадын Засгийн газраас “зөрчилтэй” гэх тодотголтой бүлэг этгээдэд хамруулах ойлголт. Хамаарал бүхий этгээд цагаачлалын нэхэмжлэл болон саатуулагдсан асуудлаа бие даасан журмын дагуу хэлцүүлнэ.

Томилогдсон албан төлөөлөгч:

18-аас доош насны болон бие даан цагаачлалын нэхэмжлэл гаргах, хэлцүүлэх чадваргүй этгээдийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах үүрэгтэй IRB-RPD-оос томилогдсон тусгай төлөөллийг хэлнэ. Энэ нь ихэнх тохиолдолд тухайн нэхэмжлэгчийн эцэг/эх, түүний гэр бүлийн гишүүн, найз эсвэл нийгмийн ажилтан байдаг.

Хориотой этгээд:

“Дүрвэгсдийн Конвенци”, “Хамгаалтанд хамрагдах хуулийн этгээд”-ийн шаардлагад хууль ёсоор нийцэхгүй этгээдийг хэлнэ.

Жишээлбэл:

- Канад улсын хилийн чандад ноцтой гэмт хэрэгт холбоотой этгээд
- Өөр нэгэн аюулгүй улс оронд амьдрах, оршин суух эрхтэй эсвэл иргэний харьяалалтай

Хурдасгасан процесс:

Нэхэмжлэгчийн оролцоогүйгээр шүүх хурлын шийдвэр гарах үндэслэлтэй гэж IRB-RPD-аас тодорхойлсон бол нэхэмжлэл хэлэлцүүлэх явц хурдасдаг. Энэхүү процесст таны нэхэмжлэл хамрагдах эсэхийг IRB-RPD-аас мэдэгднэ. Ямар хүн болон ямар нөхцөл байдлын улмаас хурдасгасан процесст хамрагддаг талаарх ойлголтыг www.kinbrace.ca/rhp-guide/updates цахим хуудаснаас авна уу.

Дарамт /шахалт:

Онц ноцтой бөгөөд нэг бус удаа тохиолдсон, хүний эрхийг зөрчсөн, заналхийлэлийн хив шинжтэй хортой үйлдлийг хэлнэ. Ойлгоход их төвөгтэй эрхзүйн ухагдахуун учраас таны түүх/нэхэмжлэлд холбогдох хамаарлыг өмгөөлөгчтэй зөвлөлдөх шаардлагатай. Дарамт/шахалтын ойлголтод эрүү шүүлт, зодуур нүдүүр, амь насанд заналхийлэх, үр тогтоох чадваргүй болгох (зарим улсын жишээгээр) эрэгтэй хүнийг албадан засах, эмэгтэй хүний хөвчийг албадан таслах, албадан гэрлүүлэх, тайван замаар үлс төрийн үзэл бодлоо илэрхийлсэнд хорих ял тулгах болон хүчингийн хэрэг зэргийг хэлнэ.

Тусгайлсан хурал:

Таны цагаачлалын нэхэмжлэлийг “хэрэгсэхгүй” болгох эсэхийг шийдэх шүүх хурлыг хэлнэ. ВОС/нэхэмжлэлээ хуулийн хугацаанд хүлээлгэж өгөөгүй эсвэл шүүх хуралд товолсон хугацаанд биечлэн оролцоогүй тохиолдолд та тусгайлсан хурлаар орох үүрэгтэй. Таны “Шүүх хуралд биечлэн оролцох мэдэгдэл”-д тусгайлсан хурлын өдрийг тодорхой заасан байх болно.

Эмзэг этгээд:

Онц ноцтой нөхцөл шалтгааны улмаас ердийн шүүх хурлын орчинд хэт эмзэг, тусгай орчин нөхцөл шаардагдах нэхэмжлэгчийг хэлнэ. Өвчин зовлон, өндөр нас эсвэл өөрт тохиолдсон гай гамшигийн шалтгааны улмаас шүүхийн өмнө тайлбар хийх боломжгүй, сэтгэлийн гүн дарамтанд байгаа этгээдийг хэлнэ. Ямар тусгай нөхцөл шаардаж болох вэ? Жишээ нь: та хэт их тулгамдаж, сандарч самуурвал богино завсарлага авах эрхтэй. Хэрвээ та хүчирхийлэлд өртсөн эсвэл хүнд ноцтой хохирол амссан эмэгтэй хүн байгаад болсон явдлыг эрэгтэй хүний өмнө тайлбарлан ярихыг хүсэхгүй тохиолдолд шүүх хурлын шийдвэр гаргагч Presiding Member, орчуулагчийг нарыг эмэгтэй төлөөлөл байлгах хүсэлт гаргах эрхтэй. Тохиолдсон явдлаас танд хүнд ноцтой эмгэг учирсан бол та шүүх хурлын Presiding Member-г гэм, эмгэгт мэдрэмжтэй нэгэн байлгах хүсэлт гаргах эрхтэй.

Та “эмзэг этгээд” мөн бол өөрөө, эсвэл өмгөөлөгчөөр дамжуулж IRB-RPD-д яаралтай мэдэгдэх хэрэгтэй. Шүүх хурлын орчинд танд зохистой ямар өөрчлөлт оруулах ёстой талаар IRB-RPD урьдчлан мэдээлэлтэй байх нь чухал. Зарим тохиолдолд шүүх хурлын онцгой орчин шаардах хүсэлтэнд эмчийн тодорхойлолт хавсаргах нь их нэмэртэй. IRB-RPD таныг “эмзэг этгээд” гэж үзвэл танд мэдүүлэг өгөх таатай орчин бүрдүүлэх талаар арга хэмжээ авна.

Төр захиргааны байгууллага



Цагаачлалын зөвшөөрөл хүсэх нэхэмжлэлийг хэлэлцэх шүүхийн явцад гурван бие даасан төр захиргааны байгууллага оролцдог: IRB-RPD, CIC, болон CBSA. Хэрвээ та оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаараа өөрчилсөн бол гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг **байгууллага тус бүрт мэдэгдэх ёстой**. Гарсан өөрчлөлтийг IRB-RPD-д мэдэгдэхдээ овог нэр, IRB-ийн хавцаст хэргийн (File Number) дугаар болон үйлчлүүлэгчийн (UCI) хувийн дугаараа заах ёстой. Гарсан өөрчлөлтийг CIC, CBSA-т мэдэгдэхдээ овог нэр болон үйлчлүүлэгчийн (UCI) хувийн дугаараа заах ёстой. Таны үйлчлүүлэгчийн (UCI) хувийн дугаар “Цагаачлал, оргонол нэхэмжлэгчийн баримт” дээр заасан 8 орон тоо бүхий дугаар мөн.



IRB-RPD

Канадын Цагаачлал болон Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Зөвлөл – Цагаачлалын эрхийг хамгаалах Хороо

Нэхэмжлэл шийдвэрлэх үйл явц дахь эрх үүрэг:

- Таны ВОС/нэхэмжлэлийг хянан шалгана
- Таны шүүх хурлыг удирдан зохион байгуулна
- Таны нэхэмжлэлд зөвшөөрөх, татгалзах эсэх шийдвэр гаргана
- Цагаачлалын шүүх хурлын БЭЛТГЭЛ үзүүлэн танилцуулах сургалт зохион явуулна.

Холбоо барих:

Immigration and Refugee Board of Canada
Refugee Protection Division
300 West Georgia Street, Suite 1600
Vancouver, BC V6B 6C9

Ажлын хуваарь: Даваа-Баасан гаргуудад 08:00-16:00

Утас: 604-666-5946; 1-866-787-7472
Факс: 604-666-3043

Цахим хуудас: www.irb-cisr.gc.ca

CIC - Канадын Иргэншил болон Цагаачлалын Алба

Нэхэмжлэл шийдвэрлэх үйл явц дахь эрх үүрэг:

- Таны цагаачлал хүсэх өргөдлийг (Канад улсын хилийн чандаас эсвэл тус улс дотроос гаргасан) үндэслэж таныг нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ
- Нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзвэл таны холбогдох баримтыг IRB-RPD-нд шилжүүлнэ
- Нэхэмжлэлийг эсэргүүцэж шүүх хуралд таны эсрэг маргаан үүсгэх зорилгоор Minister's Counsel байлцуулах эсвэл албан бичиг хүргүүлэх эрхтэй

Нэмэлт эрх үүрэг:

- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл болон Эрүүл мэндийн даатгал (Interim Federal Health Insurance) гаргаж өгнө

Холбоо барих:

Citizenship and Immigration Canada
Harry Hays Building
Room 210, 220 – 4th Avenue SE
Calgary, AB T2G 4X3

Ажлын хуваарь: Даваа-Баасан гаргуудад 08:00-16:00

CIC-ийн утасаар үйлчлэх төв: 1-888-242-2100

Цахим хуудас: www.cic.gc.ca

CBSA - Канадын Хилийн Үйлчилгээний Агентлаг

Нэхэмжлэл шийдвэрлэх үйл явц дахь эрх үүрэг:

- Таны цагаачлал хүсэх өргөдлийг (Канадын ОУ онгоцны бүүдлын хилийн шалган, эсвэл тус улсын хилийн боомт дээр гаргасан) үндэслэж таныг нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ
- Нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзвэл таны холбогдох баримтыг IRB-RPD-нд шилжүүлнэ
- Нэхэмжлэлийг эсэргүүцэж шүүх хуралд таны эсрэг маргаан үүсгэх зорилгоор Minister's Counsel байлцуулах эсвэл албан бичиг хүргүүлэх эрхтэй

Нэмэлт эрх үүрэг:

- Канад улсын хилийн хөдөлгөөний хяналтыг хангаж зорчигчийн тус улсад нэвтрэх эрхийг шийднэ
- Шүүх хурлаас нэхэмжлэлд татгалзсан хариу гарсан тохиолдолд таныг тус улсаас албадан гаргах үйл ажиллагааг хариуцан явуулна
- Таныг биеийн байцаалтгүй бол, эсвэл та Канадын нийгэмд хор уршиг учруулж болзошгүй этгээд, эсвэл та Канадын Цагаачлалын тухай хууль эрхзүйн шаардлагад нийцэхгүй гэж үзвэл таныг баривчлах, саатуулах эрхтэй. (саатуулагдсан тохиолдолд суллагдах эрхээ шүүх хурлаар хэлцүүлэх, өмгөөлөгч авах эрхтэй.)

Холбоо барих:

Canada Border Services Agency
Room 170, 220 – 4th Avenue SE
Calgary, Alberta T2G 4X3

Ажлын хуваарь: Даваа-Баасан гаргуудад 08:00-16:00

Утас: 1-800-461-9999

Цахим хуудас: www.cbsa-asfc.gc.ca

Эх сурвалж

Хууль эрх зүйн байгууллага:

Legal Aid Alberta

Standard Life Tower
639 5 Avenue, Suite 1800
1-866-845-3425
www.legalaid.ab.ca

Цагаачлалын хууль ёсны нэхэмжлэгчдэд үнэ төлбөргүй мэдээ мэдээл, зөвлөгөө өгч шүүх хуралд төлөөлөх хуулийн итгэмжлэгч зуучилна.

University of Ottawa Refugee Assistance Program

ccrweb.ca/en/uorap
Нэхэмжлэлийн нотлох баримт бүрдүүлэхэд зөвлөн тусална.

Calgary Legal Guidance

840 7th Avenue SW, Suite100
403-234-9266
www.clg.ab.ca

Цагаачлалын нэхэмжлэгчид горилөгчдод хууль эрх зүй үнэ төлбөргүй мэдээ мэдээл, зөвлөгөө өгч шүүх хуралд төлөөлөх хуулийн итгэмжлэгч зуучилна.

Олон нийтийн байгууллага:

MOSAIC Refugee Health Clinic

Marlborough Mall Professional Building
433 Marlborough Way NE, Unit 530
403-569-7251
www.mosaicpcn.ca/Services/Access/Pages/RefugeeHealthClinic.aspx

Цагаачлалын нэхэмжлэгчдэд эрүүл мэндийн, нийгмийн үйлчилгээ үзүүлж тусгайчилсан мэдээ мэдээллээр ханган тусална.

Calgary Catholic Immigration Society

Margaret Chisholm Resettlement Centre
23 McDougall Court NE
403-262-8132
www.ccis-calgary.ab.ca

Цагаачлалын нэхэмжлэгчдийг амьдрах байрны мэдээллээр хангаж, түргэн тусламжийн анхан шатны үйлчилгээ үзүүлж хуулийн зөвлөгөө өгнө.

Calgary Immigrant Women's Association

138 4th Avenue SE, Suite 200
403-263-4414
www.ciwa-online.com

Цагаачлалын нэхэмжлэгч эмэгтэйчүүдийг амьдрах байрны мэдээллээр хангаж, түргэн тусламжийн анхан шатны үйлчилгээ үзүүлж хуулийн зөвлөгөө өгнө.

Centre Accueil Nouveaux Arrivants Francophones

840 7eme Avenue SW, Suite 1601, Box 5
403-532-6334
www.canaf-calgary.ca

РЦагаачлалын Франц хэлтэй нэхэмжлэгчдэд орчуулагч, хөтөч гаргах, түргэн тусламжийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх, амьдрах байрны мэдээлэл болон хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээ явуулна.



www.kinbrace.ca цахим хуудсаас тус гарын авлагыг дараах хэлээр унших боломжтой: *(Алберта муж, Калгари хот)*

- Англи
- Франц
- Испани
- Монгол
- Урдү /Энэтхэг
- Араб

Төслийг дэмжин ажилласан өгөөмөр хамтрагчиддаа гүн талархал илэрхийлье:



Тус гарын авлагыг бүтээх болон сайжруулан боловсруулахад цаг заваа харамгүй зарцуулсан, санал бодлоо хуваалцан бүтээлч хандсан түршлагажсан (цагаач, хуульч, холбогдох үйлчилгээний салбрынхан гэх мэт) оролцогчдодоо гүн талархал илэрхийлье.



Kinbrace- манай байгууллагын үүд хаалга цагаачлалын нэхэмжлэгчдэд орон байр, танилцах, дагалдах болон сургалтын үйлчилгээ үзүүлэхэд ямагт нээлттэй. Бидний үйл ажиллагаа хамтын болон зочломтгой харилцаанд суурилсан болно.

Зохиогчийн эрх **Kinbrace Community Society** 2015 он

Жич: Энэхүү гарын авлагад орсон мэдээ мэдээлэл нь тухайн цаг хугацаандаа бүрэн нийцсэн үнэн зөв бөгөөд хэвлэгдсэнээс хойш гарах мэдээ мэдээллийн өөрчлөлтөд хариуцлага хүлээхгүй болно.

Зургийг: Армстронг Андреа